




НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



**МОНГОЛ УЛСЫН  
ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН  
ХЭРЭГЖИЛТ:  
ШҮҮГЧИЙН СОНГОН  
ШАЛГАРУУЛАЛТ**





НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ: ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

---

Багийн ахлагч: П.Баттулга - Оюуны-Инноваци ТББ-ын судлаач, хуульч

Багийн гишүүн: Б.Төрболд - Оюуны-Инноваци ТББ-ын судлаач, хуульч

Багийн гишүүн: С.Цэрэндолгор - судлаач, хуульч

---

Улаанбаатар хот  
2026 он

ННА 67  
ДАА 340  
Т-594



## МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ: ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

Багийн ахлагч: П.Баттулга - Оюуны-Инноваци ТББ-ын судлаач, хуульч

Багийн гишүүн: Б.Төрболд - Оюуны-Инноваци ТББ-ын судлаач, хуульч

Багийн гишүүн: С.Цэрэндолгор - Судлаач, хуульч

© Нээлттэй Нийгэм Форум, 2026  
Уг тайланг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

Л.Түдэвийн гудамж-5/3, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар - 14240, Монгол Улс  
Утас: 76113207  
<http://www.forum.mn>  
<http://www.twitter.com/ForumOS>  
<http://facebook/OpenSocietyForum>  
[http://www.instagram.com/open\\_society\\_forum](http://www.instagram.com/open_society_forum)

ISBN: 978-9919-529-10-9

# Агуулга

---

ӨМНӨХ ҮГ .....	5
ОРШИЛ .....	7
НЭГ. Шүүгчийг сонгон шалгаруулах тогтолцоо.....	9
ХОЁР. Шүүгчид нэр дэвших хүсэлт гаргах, шүүгчид нэр дэвшигчийг бүртгэхтэй холбоотой асуудал .....	12
ДӨРӨВ. Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх.....	21
ТАВ. Шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх арга, хэлбэр .....	28
5.1. Шүүгчид нэр дэвшигчийг хууль зүйн мэдлэг, чадварыг үнэлэх нь .....	28
А. Шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварын үнэлэх арга, хэлбэрийг өөрчлөх шаардлага.....	31
Б. Канад Улсын дээд шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтын туршлага .....	35
5.2. Шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг шалгах арга хэлбэр .....	39
А. Америкийн Нэгдсэн Улсын туршлага.....	43
Б. Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын туршлага .....	45

ЗУРГАА. Ерөнхий зөвлөлөөс шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх .....	51
6.1. Нөөцөд байгаа нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгох .....	53
ДОЛОО. Ерөнхийлөгч шүүгчийг томилох нь .....	57
НАЙМ. Шүүгчийн сонгон шалгаруулалтын нээлттэй, ил тод байдал.....	69
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	76
НОМ ЗҮЙ.....	80
ХАВСРАЛТ.....	82

**Ш**ударга, хараат бус шүүх засаглал нь ардчилсан нийгмийн тулгуур багана бөгөөд үүний үндэс нь мэдлэг чадвартай, ёс зүйтэй шүүгчийг шилж сонгох ил тод, шударга тогтолцоо байдаг. 2021 онд Монгол Улсын шүүхийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаар шүүгчийг сонгон шалгаруулах үйл явцад зарчмын томоохон өөрчлөлтүүд орсон билээ. Тухайлбал, шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө хариуцаж, шалгалтын үнэлгээний эрэмбийг баримтлан томилуулах санал гаргадаг болсон нь улс төрийн нөлөөллийг бууруулах чухал алхам болсон юм.

Нээлттэй Нийгэм Форум нь засаглалын ил тод байдлыг хангах, хүний эрхийг хамгаалах, шүүх эрх мэдлийн шинэчлэлийг дэмжих зорилгынхоо хүрээнд шүүхийн тогтолцоо дахь бодлогын судалгаа, хяналт шинжилгээг тогтмол дэмжиж ирсэн/дэмждэг бөгөөд энэ удаад “Оюуны-Инноваци” ТББ-аас ирүүлсэн саналыг дэмжиж, шинэ хууль хэрэгжиж эхэлснээс хойших шүүгчийн сонгон шалгаруулалтын бодит практик, үр дагаварт хийсэн шинжилгээний тайланг Та бүхэнд хүргэж байна.

П.Баттулга ахлагчтай судалгааны баг маань 2015 онд “Шүүхийн томилгооны хараат бус байдал” сэдэвт анхны бие даасан сэдэвчилсэн бодлогын судалгааг хийж гүйцэтгэсэн нь шүүх эрх мэдлийн салбарын томилгооны хараат бус байдлыг үнэлэх анхны томоохон бие даасан судалгаа болж байв. Энэ удаад бид дахин хамтран ажиллаж энэхүү судалгааг шинэчлэн өнөөдрийн тулгамдаж буй асуудлуудыг нарийвчлан авч үзлээ.

Судалгааны үр дүнгээс харахад цахим бүртгэлийн систем дэх техникийн саад бэрхшээл, шалгалтын даалгаврын тодорхойгүй байдал, дээд шатны шүүгчид нэр дэвшигчдээс шаардах материалын давхардал зэрэг нь нэр дэвшигчдэд чирэгдэл учруулж буйг онцолжээ. Мөн шүүгчийн сонгон шалгаруулалтад хөндлөнгийн мэргэшсэн хороог оролцуулах, үнэлгээний аргачлалыг илүү боловсронгуй болгох шаардлага байгааг олон улсын туршлагад үндэслэн гаргаж ирсэн байна.

Бидний зүгээс энэхүү судалгааны дүгнэлт, санал зөвлөмжүүд нь шинээр томилогдоод буй Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, улмаар шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна. Судалгааг гүйцэтгэсэн баг хамт олон болон судалгаанд оролцож үнэтэй санал, мэдээллээ хуваалцсан шүүгч, хуульчдад талархал илэрхийлье.

*П.Эрдэнэжаргал*

*ННФ-ын Гүйцэтгэх захирал*

2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлагдаж, мөн оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж байгаа Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн шүүгчийн сонгон шалгаруулалтын зохицуулалт өмнө үйлчилж байсан хуулиудаас зарчмын хувьд хэд хэдэн зүйлээр өөрчлөгдсөн билээ. Үүнд 1) шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг Ерөнхий зөвлөл өөрөө хариуцан гүйцэтгэх; 2) Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг санал хураалтаар бус шалгалтын үнэлгээний эрэмбийн дагуу Ерөнхийлөгчид санал болгох; 3) шүүгчийн томилгоо дахь Ерөнхий зөвлөл ба Ерөнхийлөгчийн харилцаатай холбоотой зохицуулалтыг шинээр бий болгосон зэрэг гол өөрчлөлтийг дурдаж болно.

2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хууль хэрэгжиж эхлэхээс өмнө Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалтын тогтолцоог хэм хэмжээ, онол, практикийн түвшинд судалсан цөөнгүй судалгааны ажил хийгдэж нийтийн хүртээл болсон.<sup>1</sup> Харин 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш шүүгчийн сонгон шалгаруулалтын хүрээнд хийсэн судалгааны ажил байхгүй байна. Иймд “Оюуны-Инноваци” ТББ-аас Нээлттэй Нийгэм Форумд хандаж шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой Монгол Улсын шүүхийн

---

<sup>1</sup> Шүүгчийн сонгон шалгаруулалтын талаар дагнан бичигдсэн судалгааны ажлууд гэвэл “О.Мөнхсайхан “Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт: Шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг сайжруулах нь” (2015) нэг сэдэвт бүтээл, П.Баттулга М.Мөнхжаргал, Ж.Хунан “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: Шүүгчийн томилгоо” (2015) судалгааны тайлан. П.Баттулга “Монгол Улсын шүүхийн томилгооны системийг боловсронгуй болгох нь” (2020) өгүүлэл” зэргийг нэрлэж болно. Мөн дагнан судлаагүй ч шүүгчийн сонгон шалгаруулалтын талаар орсон цөөнгүй бүтээл бий.

тухай хуулийн зохицуулалт, түүний хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ, мониторинг хийх санал тавьсан бөгөөд бидний саналыг дэмжиж, санхүүгийн дэмжлэг үзүүлсэнд талархлаа илэрхийлье. Судалгааны ажлыг П.Баттулга, Б.Төрболд, С.Цэрэндолгор хамтран гүйцэтгэлээ.

Судалгааны хүрээнд шүүгчдээс шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотойгоор асуумж авснаас 34 шүүгч хариулт илгээсэн. Мөн судалгааг гүйцэтгэхдээ хэм хэмжээний түвшинд буюу эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх, тоон мэдээлэл ашиглах, шүүхийн практик судлах, харьцуулсан судалгаа хийх зэрэг аргыг ашигласан болно. Шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотойгоор Шүүхийн ерөнхий зөвлөл рүү албан ёсоор хандаж тоон мэдээлэл авсан бөгөөд зарим баримт, тоон мэдээллийг өгөөгүй, тодорхой хариу ирүүлээгүй болохыг тэмдэглэж байна.

## Нэг. Шүүгчийг сонгон шалгаруулах ТОГТОЛЦОО

Монгол Улсад шүүгч сонгон шалгаруулах ажиллагаа Монгол Улсын Үндсэн хууль, 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хууль болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”<sup>2</sup>-д зааснаар дараах долоон үе шаттай: (1) Шүүгчийн орон тоо буюу шүүгчийн сонгон шалгаруулалт зарлах, (2) Өргөдөл гаргагч баримт бичгээ Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба (Цаашид “ажлын алба” гэх)-нд ирүүлэх, (3) Шүүхийн ерөнхий зөвлөл (цаашид “Ерөнхий зөвлөл” гэх) баримт бичгийг нягтлан шалгаж, шүүгчид нэр дэвшигчээр бүртгэх эсэхийг шийдвэрлэх, (4) Бүртгэсэн нэр дэвшигчийг нийтэд мэдээлэх, (5) Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийг үнэлж, эрэмбэлэх, (6) Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх, (7) Ерөнхийлөгч шүүгчийг томилох.<sup>3</sup>

- 1) Шүүгчийн сонгон шалгаруулалт зарлах. Шүүгч сонгон шалгаруулах ажиллагаа нь шүүгчийн сул орон тоо бий болсноор эхэлнэ. Шүүгчийн сонгон шалгаруулалт зарлах гурван үндэслэлийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасан. Ерөнхий зөвлөл шүүгчийн сонгон шалгаруулалт зарлах үндэслэл үүссэн тохиолдолд сонгон шалгаруулалтын зарыг байгууллагын албан ёсны цахим хуудас болон хэвлэл мэдээллийн

<sup>2</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468267018881>

<sup>3</sup> Гэхдээ Монгол Улсын бүх шүүгчийг томилох ажиллагаа дээрх бүх үе шатны дагуу хийгддэг гэж ойлгож болохгүй бөгөөд Үндсэн хуульд зааснаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг шүүгчдийнх нь дотроос санал болгосноор Ерөнхийлөгч томилдог бол Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн Зөвлөгөөн сонгодог. – П.Б

хэрэгслээр нийтэд мэдээлнэ. Энэхүү зард шүүгчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх болзол, шаардлага, өргөдөл, хавсралт баримт бичгийг хүлээн авах, бүртгэх, сонгон шалгаруулах хугацаа, журам, газрыг тодорхойлсон байна. Шүүгчийн сонгон шалгаруулалт зарлах Ерөнхий зөвлөлийн тогтоол гарна.<sup>4</sup>

- 2) Өргөдөл гаргагч баримт бичгээ ажлын албанд ирүүлэх. Шүүгчид тавигдсан болзол, шаардлагыг хангасан иргэн шүүгчийн сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор шүүгчид нэрээ дэвшүүлэх эрхтэй. Өргөдөл гаргагч Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх сонгон шалгаруулах журам”-ын 3.3-т заасан баримт бичгийг бүрдүүлж Ажлын албанд цаасаар болон цахимаар хүргүүлнэ.
- 3) Ерөнхий зөвлөл баримт бичгийг нягтлан шалгах, шүүгчид нэр дэвшигчээр бүртгэх эсэхийг шийдвэрлэх. Ерөнхий зөвлөл шүүгчид өргөдөл гаргагчийн баримт бичгийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор бүрэн гүйцэд, үнэн зөв эсэхийг нягтлан шалгаж, шүүгчид нэр дэвшигчээр бүртгэсэн, эсхүл бүртгэхээс татгалзсан тухай тогтоол гаргана.
- 4) Бүртгэсэн нэр дэвшигчийг нийтэд мэдээлэх. Шүүгчид нэр дэвшигчээр бүртгэх тухай Ерөнхий зөвлөлийн тогтоол гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор нэр дэвшигчийн баримт бичгийг Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулах бөгөөд хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг нийтлэхгүй. Энэ мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналаа Ерөнхий зөвлөлд ирүүлж болох бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг хүлээн авахгүй.
- 5) Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийг үнэлж, эрэмбэлэх. Шүүгчид нэр дэвшигчийг бүртгэснээс хойш Ерөнхий зөвлөл 60 хоногийн дотор шүүгчид нэр дэвшигчээс хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалт авна. Шалгалт

<sup>4</sup> Өмнө нь үйлчилж байсан эрх зүйн зохицуулалтаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын тушаал гардаг байсан.

нь нийт 100 хүртэл оноогоор үнэлэгдэхээс хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт 70 хүртэл оноотой бөгөөд 50, түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад оруулна. Энэ шалгалт 30 хүртэл оноотой ба 20, түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг шалгалтад тэнцсэн тооцно.<sup>5</sup> Ерөнхий зөвлөл шалгалтад тэнцсэн нэр дэвшигчдийг шалгалт тус бүрийн болон нийлбэр онооны дарааллаар эрэмбэлж, цахим хуудастаа мэдээлнэ.


- 6) **Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх.** Ерөнхий зөвлөл шүүгчийн нэр дэвшигчийн шалгалтын үнэлгээний эрэмбийн дагуу нийтэд мэдээлснээс хойш ажлын таван өдрийн дотор зарлагдсан орон тоогоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг шүүгчээр томилуулах саналыг, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулснаар томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ.
- 7) **Ерөнхийлөгч шүүгчийг томилох.** Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч 14 хоногийн дотор томилно.

<sup>5</sup> Өмнө нь шүүгчид нэр дэвшигчийн шалгалтад 100 онооноос бүх шалгалтын нийлбэр дүнгээр 60-аас доошгүй оноо авсан нэр дэвшигчийг шалгалтад тэнцсэнд тооцдог байсан бол Монгол Улсын шүүхийн тухай хуулиар хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад тэнцэх босго болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад тэнцэх босгыг тус тусад нь тогтоож, онооны босгыг 70 болгож өндөрсгөсөн.

## Хоёр. Шүүгчид нэр дэвших хүсэлт гаргах, шүүгчид нэр дэвшигчийг бүртгэхтэй холбоотой асуудал

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т “Энэ хуулийн 33.1-д заасны дагуу өргөдөл гаргагч нь ... өргөдөл, анкет, мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга, оршин суугаа газрын хаяг, гэр бүлийн болон эд хөрөнгийн эрхийн лавлагаа, Монгол Улсын иргэний үнэмлэх, мэргэжлийн боловсролын диплом, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр, хөдөлмөр эрхлэлтийн талаарх болон бусад баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт Ерөнхий зөвлөлд цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ” гэж заасан. Мөн Ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-д шүүгчид нэр дэвших хүсэлт гаргагчийн бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг баталсан. Шүүгчид нэр дэвшихээр хүсэлт гаргагч нь баримт бичгээ шүүгчийн сонгон шалгаруулалтын цахим систем ([selection.judges.mn](http://selection.judges.mn))-ээр цахимаар, мөн давхар цаасаар ажлын албанд хүргүүлж байна.

2022-2025 оны хооронд зохион байгуулсан 9 удаагийн сонгон шалгаруулалтад анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд нийт 1576 хуульч нэрээ дэвшүүлснээс 1226 хуульчийг нэр дэвшигчээр бүртгэж, 350 хуульчийг бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна. Нэр дэвшигчээр бүртгэгдсэн хуульчдын 81.5% нь анхан шатны шүүх, 15.2% нь давж заалдах шатны шүүх, 3.2% нь хяналтын шатны шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэгджээ.



Ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дэх хэсэгт дараах үндэслэлийн аль нэг байгаа тохиолдолд өргөдөл гаргагчийг шүүгчид нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзахаар заажээ.

### Хүснэгт 1. Шүүгчид нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл

4.3.Ерөнхий зөвлөл анхан шатны шүүхийн шүүгчид нэрээ дэвшүүлсэн өргөдөл гаргагч иргэний баримт бичгийг нягтлан шалгаж доор дурдсан үндэслэлийн аль нэг байгаа тохиолдолд шүүгчид нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай тогтоол гаргана:

4.3.1.иргэн өргөдөл, баримт бичгээ сонгон шалгаруулалтын зард заасан хугацаанд ирүүлээгүй;

4.3.2.энэ журмын 3.3-т заасан баримт бичгийн аль нэг нь дутуу;

4.3.3.өргөдөл гаргагч иргэний баримт бичиг үнэн зөв бус;

4.3.4.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзлыг хангаагүй;

4.3.5.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1-31.1.4 дэх заалт, 31.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй.

4.3.6.энэ журмын 3.10-3.12-т<sup>6</sup> заасан нэр дэвшиж буй шүүхийг өргөдөлд болон цахим системд тодорхойлоогүй;

4.3.7.энэ журмын 4.11-д заасан нөхцөл бий болсон;

4.3.8.шүүгч адил шатны ижил төрлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэдэг шүүхэд нэрээ дэвшүүлсэн.

<sup>6</sup> 3.10.Иргэн хэргийг дараах төрлөөр харьяалан шийдвэрлэх анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд нэрээ дэвшүүлнэ:

3.10.1.эрүүгийн хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх;

3.10.2.иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх;

3.10.3.захиргааны хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх;

3.10.4.эрүү, иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх.

3.10.5.Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх;

3.10.6.Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх.

4.4.Ерөнхий зөвлөл давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэрээ дэвшүүлсэн иргэний баримт бичгийг нягтлан шалгаж дараах үндэслэлийн аль нэг байгаа тохиолдолд шүүгчид нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай тогтоол гаргана:

4.4.1.энэ журмын 4.3.1, 4.3.3-4.3.8 заасан үндэслэл;

4.4.2.энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан<sup>7</sup> баримт бичгийн аль нэг нь дутуу;

4.4.3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 31.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй.

4.5.Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхийн шүүгчид нэрээ дэвшүүлсэн өргөдөл гаргагч иргэний баримт бичгийг нягтлан шалгаж дараах үндэслэлийн аль нэг байгаа тохиолдолд нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай тогтоол гаргана:

4.5.1.энэ журмын 4.3.1, 4.3.3-4.3.8 заасан үндэслэл;

4.5.2.энэ журмын 3.5.1, 3.5.2-т заасан<sup>8</sup> баримт бичгийн аль нэг нь дутуу;

4.5.3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4, 31.5 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй.

Шүүгчийн сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан үндэслэл, шалтгаан нөхцөлийг судалж үзэхэд 9 удаагийн сонгон шалгаруулалтын хүрээнд нэрээ дэвшүүлсэн хуульчдын 53% нь баримт бичгийн бүрдэл дутуу, 20 хувь нь нэр дэвших шүүхийн төрлөө өргөдөл болон цахим системд тодорхойлоогүй үндэслэлээр нэр дэвшигчээр бүртгэгдэж чадаагүй<sup>9</sup> тоон үзүүлэлт дийлэнх хувийг эзэлж байна.

3.11.Иргэн хэргийг дараах төрлөөр харьяалан шийдвэрлэх давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд нэрээ дэвшүүлнэ:

3.11.1.эрүүгийн хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх;

3.11.2.иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх;

3.11.3.захиргааны хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх;

3.11.4.эрүү, иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх.

3.11.5.Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх.

3.12.Иргэн хяналтын шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тавих болзол, шаардлагыг хангасан бол Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд нэрээ дэвшүүлнэ.

<sup>7</sup> 3.4.Иргэн давж заалдах шатны шүүхийн шүүгчид тавих болзол, шаардлага хангасан тухай дараах баримт бичгийг эх хувиар, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өргөдөлд хавсаргана:

3.4.1.шүүгч нэрээ дэвшүүлж байгаа бол энэ журмын 3.3.3, 3.3.4, 3.3.6, 3.3.7, 3.3.9-3.3.12-т заасан баримт бичиг;

3.4.2.шүүгчээс бусад хуульч нэрээ дэвшүүлж байгаа бол энэ журмын 3.3-т заасан баримт бичиг;


<sup>8</sup> 3.5.Иргэн Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид тавих болзол, шаардлага хангасан тухай дараах баримт бичгийг эх хувиар, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өргөдөлд хавсаргана:

3.5.1.шүүгч нэрээ дэвшүүлж байгаа бол энэ журмын 3.3.3, 3.3.4, 3.3.6, 3.3.7, 3.3.9-3.3.12-т заасан баримт бичиг;

3.5.2.шүүгчээс бусад хуульч нэрээ дэвшүүлж байгаа бол энэ журмын 3.3-т заасан баримт бичиг;

<sup>9</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албанаас 2025.09.09-нд авсан тоон мэдээлэл.

Шүүгчид нэр дэвших хүсэлт гаргах, шүүгчид нэр дэвшигчийг бүртгэхтэй холбоотой асуудал



Өргөдөл гаргагч цаасан хэлбэрээр бүх баримт бичгээ Ерөнхий зөвлөлд хүргүүлсэн боловч цахим системд нэр дэвших шүүхээ сонгоогүй гэдэг үндэслэлээр нэр дэвшигчээс хасагдаж, улмаар шүүхэд маргаан үүсгэсэн боловч амжилт олоогүй тохиолдол гарсан байна.

*Хүснэгт 2. Б.Б-ийн нэхэмжлэлтэй Ерөнхий зөвлөлд холбогдох захиргааны хэрэг<sup>10</sup>*

**Маргааны агуулга:** Нэхэмжлэгчээс Шүүхийн ерөнхий зөвлөлд холбогдуулан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүгчийн сул орон тоонд нэр дэвшигчээр бүртгэхээс тогтоолын өөрт холбогдох хэсгийг хүчингүй болгон, нэр дэвшигчээр бүртгэхийг даалгах” тухай нэхэмжлэл гаргасан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 03 шийдвэрээр нэхэмжлэгчийг “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.3.6-д заасны дагуу нэр дэвшиж буй шүүхийг цахим системд тодорхойлоогүй гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна. Дээрх тогтоолыг хүлээн авч 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлд гаргасан гомдолд Шүүхийн ерөнхий зөвлөлийн нэхэмжлэгчид албан бичгээр “...нягтлан шалгахад цахим системд нэр дэвших үйлдлээ баталгаажуулаагүйгээс шалгалт өгөх эрх үүсээгүй байна. Иймд ... Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолын Танд холбогдох хэсгийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн болохыг мэдэгдэж байна” гэж хариу өгчээ.

<sup>10</sup> Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр. 2025.04.14, 128/ШШП2025/0261 [https://shuukh.mn/single\\_case/18526?start\\_date=&end\\_date=&id=1&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/18526?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1)

**Нэхэмжлэлийн үндэслэл, тайлбар:** Иргэн би Монгол улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хуульд заасан шүүгчийн албан тушаалд тавигдах болзол, шаардлагыг бүрэн хангасан талаарх холбогдох бүхий л нотлох баримтын хамт хариуцагч Шүүхийн ерөнхий зөвлөлд цахимаар болон цаасаар хуульд заасан хоёр хэлбэрээр гарган өгч, бүртгүүлсэн болно.

**Хариуцагчийн тайлбар:** 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 09.00 цагаас шүүгчийн сонгон шалгаруулалтын бүртгэл эхэлсэн. Иргэн Б 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 13.35 минутад материалаа өөрийн биеэр авчирч өгсөн. Нягтлан шалгах явцад захиргааны хэргийг харьяалан шийдвэрлэх анхан шатны шүүхийн шүүгчид нэрээ дэвшүүлсэн хуульч Б нь цахим системд нэрээ дэвшүүлэх үйлдэл хийгээгүй болох нь тогтоогдсон. Энэ үйл баримт нь Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журмын 4.3.6-д заасан нэр дэвшиж буй шүүхийг цахим системд тодорхойлоогүй гэсэн зохицуулалтад хамаарна.

**Шүүхийн шийдвэрийн үндэслэл:** ... системд нэхэмжлэгч 2025 оны 02 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд нэвтэрч, материал оруулсан гэх бүртгэл байх боловч шалгалт өгөх эрх нь үүссэн иргэний бүртгэлд мэдээлэл байхгүй, бүртгэл баталгаажаагүй байх тул нэхэмжлэгчийн "... 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдөр цахимаар selection.judges.mn веб сайтад нэвтрэн шүүгчийн сул орон тооны шалгалтын бүртгэлийг бүрэн гүйцэт бүртгүүлсэн ..." гэх тайлбар хэрэгт авагдсан баримтаар тогтоогдохгүй байна. Нэхэмжлэгч нь цаасан баримтыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн боловч цахимаар бүртгүүлсэн нь хэрэгт авагдсан баримтаар нотлогдохгүй байх тул Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг, Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журмын 4.1-д заасан шүүгчид нэр дэвших болзол шаардлагыг хангасан иргэн Шүүхийн ерөнхий зөвлөлд цахим хэлбэрээр холбогдох баримтыг хүргүүлэх хуулийн зохицуулалтад нийцээгүй гэж үзсэн хариуцагчийн шийдвэр үндэслэлтэй гэж үзлээ. **Хэдийгээр нэхэмжлэгч нь шүүгчийн сул орон тоонд нэр дэвшигчийн цахим бүртгэлд бүртгүүлсэн нь хэрэгт авагдсан баримтаар нотлогдоогүй ч Шүүхийн ерөнхий зөвлөл нь цаашид ийм төрлийн маргаан гарахаас сэргийлж нэр дэвшигч бүртгэгдсэн эсэх, бүртгэгдээгүй тохиолдолд тухайн нэр дэвшигчээр бүртгүүлж буй иргэнд мэдэгддэг байх зэргээр шүүгчийн сонгон шалгаруулалтын цахим системийг нэн даруй сайжруулан, боловсронгуй болгоход анхаарч ажиллах нь зүйтэй.**

2013 онд шүүгчийн сонгон шалгаруулалтын цахим системийг нэвтрүүлснээс хойш шүүгчид нэр дэвшигчийн материалыг цахимаар болон цаасаар аль аль хэлбэрээр хүлээн авч байна. Асуулгад оролцогчдоос шүүгчид нэрээ дэвшүүлэх үйл явцтай холбоотой дараах саналыг гаргасан байна.

Нэр дэвшигчийн баримт бичгийн бүрдэлтэй холбоотой асуулгад оролцогчдоос өгсөн санал, шүүмж:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлтийг орон нутагт мэргэжлийн эмч нар гаргадаг түүнийг материалд тооцдог болох одоогийн практикаар зөвхөн СЭМҮТ-өөс буюу нэг эмнэлгээс авч байгаа нь тухайн байгууллагад зохиомол ачаалал үүсгэхээс гадна шалгалтад нэр дэвшигчид хүндрэл үүсгэж буйг өөрчлөх;
2. Нөөцөд байгаа нэр дэвшигчээс дахин материал бүрдүүлж авч байгааг болиулах, нэр дэвших хүсэлтээ өгөөд болдог байсан өмнөх зохицуулалтыг сэргээх;
3. Цахим шүүх хүрээнд давж заалдах, хяналтын шатны шүүхэд нэр дэвшиж буй шүүгчийн материалыг Ерөнхий зөвлөлийн хүний нөөцийн программаас шууд татах боломжийг нээж өгөх

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “Шүүгчээр томилогдон ажиллахад харшлах өвчний жагсаалт болон энэ хуулийн 40.2.2-т заасан эрүүл мэндийн шалтгааныг тогтоох журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална” гэж заасны дагуу Ерөнхий зөвлөлийн дарга, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 75, А/205 дугаар тушаалаар “Шүүгчээр ажиллахад харшлах өвчний жагсаалт”-ыг<sup>11</sup>, мөн хамтарсан 2022 оны Дугаар 76, А/206 дугаар тушаалаар “Шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болох эрүүл мэндийн шалтгааныг тогтоох журам”-ыг<sup>12</sup> тус тус баталсан байна. Шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болох эрүүл мэндийн шалтгааныг тогтоох журмын 2.3-т “Шүүгч нь шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэгтэй эсэхийг гагцхүү Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн мэргэжлийн зэрэг цолтой, 3 ба түүнээс дээш эмчийн бүрэлдэхүүнтэй комисс тогтооно” гэж заасны дагуу шүүгчид нэр дэвших хүсэлт гаргагч нь шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадлагааг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөр гаргуулж байна.

Харин шүүгчээр ажиллаж байгаа хүн дээд шатны шүүхэд нэр дэвшихэд “шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадлагаа”-г гаргуулахын үр дагавар нь ойлгомжгүй байна. Учир нь “тухайн хүн

<sup>11</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468349969621>

<sup>12</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468349744541>

шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй” үндсэн дээр шүүгчээр ажиллаж байгаа гэж үзнэ. Харин уг шүүгч шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэгтэй эсэхийг “Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын дагуу гаргасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн” гаргуулахаар Шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болох эрүүл мэндийн шалтгааныг тогтоох журмын 2.2-т заасан байна.

Ерөнхий зөвлөл шүүхийн хүний нөөцийн бодлогын хүрээнд шүүгчийн хувийн хэрэг буюу тухайн шүүгчтэй холбоотой баримт бичгүүдийг хадгалж, баяжуулж байдаг тул шүүгчээр ажиллаж байгаа хүн дээд шатны шүүхэд нэр дэвшиж байгаа тохиолдолд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7-д “нийтийн мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх” гэж заасны дагуу өргөдөл гаргагч шүүгчээс шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцох бүрд өөрт хадгалагдаж байгаа баримт, мэдээллийг нь давхардуулан авахгүй байх үүрэгтэй байна.

Иймд цаашид өргөдөл гаргагчийн материалыг цаасан эсхүл цахимын аль нэг хэлбэрээр хүлээн авдаг болох, механик ажиллагааны улмаас шүүгчид нэр дэвшигчээр бүртгэгдэхгүй байхаас урьдчилан сэргийлж баримт бичгийн бүрдэлтэй алдаагаа засах боломжийг өргөдөл гаргагчид олгож байх, цахим системд баримт бичгээ дутуу оруулсан, шаардлагатай үйлдэл хийгээгүй тохиолдолд сануулга, мэдэгдэл харуулдаг байх, мөн нөөцөд бүртгүүлсэн болон одоо ажиллаж байгаа шүүгч дээд шатны шүүхэд нэр дэвших тохиолдолд Ерөнхий зөвлөл өөрт байгаа мэдээллийг өргөдөл гаргагчаас дахин шаардахгүй байх зэрэг өөрчлөлт хийх нь зүйтэй байна.

Гурав. Нэр дэвшигчийн мэдээллийг олон нийтэд мэдээлэх, санал авах

Шүүгчид нэр дэвшигчийг бүртгэсний дараа түүний мэдээлэл (товч намтар, мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга)-ийг нийтэд ил болгож, санал авах ажиллагаа нь 2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар анх бий болсон бөгөөд энэ зохицуулалт Монгол Улсын шүүхийн тухай хуульд уламжлагдан мөрдөгдөж байна. Монгол Улсын

шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-т "... нэр дэвшигчийн баримт бичгийг Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулах бөгөөд хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг нийтлэхгүй", 33.5-д "Энэ хуулийн 33.4-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналаа Ерөнхий зөвлөлд ирүүлэх бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг хүлээн авахгүй" гэж заасан. Үүний дагуу Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг бүртгэсэн тогтоол гарсан даруй нэр дэвшигчийн мэдээлэл (зураг, боловсрол, ажлын туршлага)-ийг өөрийн цахим хуудас, олон нийтийн сүлжээний хаягтаа байршуулж байна.

*Хүснэгт 3. Шүүгчид нэр дэвшигчийн талаар олон нийтээс санал авахаар мэдээлэл байршуулж байдал*

**Шүүгчийн сонгон шалгаруулалтад нэр дэвшигчдийг бүртгэлээ**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит бус хуралдаанаар анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад 135 нэр дэвшигчийг бүртгэлээ.

Эрүү, Иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх анхан шатны шүүхийн шүүгчийн 19 сул орон тоонд 95 нэр дэвшигчийг, Захиргааны хэргийг харьяалан шийдвэрлэх анхан шатны шүүхийн шүүгчийн 2 сул орон тоонд 24 нэр дэвшигчийг, Эрүүгийн хэргийг харьяалан шийдвэрлэх давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 1 сул орон тоонд 4 нэр дэвшигчийг, Иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 3 сул орон тоонд 10 нэр дэвшигчийг, Эрүү, Иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 8 сул орон тоонд 2 нэр дэвшигчийг тус тус 260 дугаар тогтоолоор бүртгэлээ.

Нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг 14 хоногийн хугацаанд [shuugch-songon@judcouncil.mn](mailto:shuugch-songon@judcouncil.mn) цахим хаягаар хүлээн авч байна. Та нэр дэвшигчтэй холбоотой асуулт, саналаа ирүүлнэ үү.

Жишээлбэл, дээрх мэдээллээс үзвэл Ерөнхий зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 260 дугаар тогтоолоор шүүгчийн сонгон шалгаруулалтад бүртгэгдсэн 135 нэр дэвшигчийн мэдээллийг мөн өдөр цахим хуудас<sup>13</sup>, олон нийтийн сүлжээний хаягтаа байршуулсан. Энэхүү тогтоолоор захиргааны хэргийг харьяалан шийдвэрлэх анхан шатны шүүхийн шүүгчийн 2 сул орон тоонд 24 хүнийг бүртгэсэн байх бөгөөд хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад 6 нэр дэвшигч тэнцсэнийг Ерөнхий зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн

<sup>13</sup> [https://www.judcouncil.mn/site/news\\_full/15402](https://www.judcouncil.mn/site/news_full/15402)

хуралдаанаар баталгаажуулж<sup>14</sup>, улмаар эдгээр 6 нэр дэвшигчийн мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулгыг 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр нийтэд мэдээлсэн.<sup>15</sup> Үүнээс харахад олон нийт 14 хоногийн хугацаанд 135 нэр дэвшигчийн мэдээлэлтэй танилцаж, асуулт, саналаа Ерөнхий зөвлөлд илгээхэд төвөгтэй. Мөн Ерөнхий зөвлөл хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад тэнцсэн нэр дэвшигчийн мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулгыг нийтэд мэдээлж байгаа боловч энэ нь олон нийтээс санал авах хугацаа дууссаны дараа хийгдэж байна.

Шүүгчид нэр дэвшигчийн талаар олон нийтээс санал авах нь нэр дэвшигчийн ёс зүй, зан төлөвийг судлах, үнэлэхэд чухал арга юм. Гэтэл бүртгэгдсэн бүх нэр дэвшигчийн мэдээллийг нийтэд ил болгож, 14 хоногийн хугацаанд олон нийтээс санал авах ажиллагааг хийж байгаа нь уг ажиллагааг үр дүн муутай болгож байна. Бүртгэгдсэн нэр дэвшигчийн ёс зүй, зан төлөвийн талаар олон нийт санал илгээлээ ч уг нэр дэвшигч хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад тэнцээгүй тохиолдолд тухайн санал үр дагаваргүй болохоор байна. Практикт шүүгчид нэр дэвшигчийн талаар олон нийтээс ирүүлж байгаа санал их байдаггүйг ажлын албанаас судалгааны явцад хэлсэн.

Нөгөөтээгүүр, хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад тэнцсэн нэр дэвшигчийн мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулгыг нийтэд мэдээлж байгаа нь зүйтэй боловч энэ нь олон нийтээс санал авах хугацаа дууссаны дараа болж байгаа тул олон нийтийн санал тунхаг төдий, сонгон шалгаруулалтын үйл явцыг нийтэд мэдээлж байгаа хэлбэр болж байна. Иймд хууль зүйн мэдлэг, ур чадварын шалгалтад тэнцэж, ёс зүй, зан төлөвийн шалгалтад орох эрхтэй болсон нэр дэвшигчийн талаар буюу богино жагсаалт үүссэний дараа тухайн нэр дэвшигчийн тухай олон нийтээс мэдээлэл, санал авдаг байх нь уг аргыг илүү үр дүнтэй болгохоор байна

<sup>14</sup> [https://www.judcouncil.mn/site/news\\_full/15487](https://www.judcouncil.mn/site/news_full/15487)

<sup>15</sup> <https://www.judcouncil.mn/site/news/38?keyword=&page=3>

## Дөрөв. Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх

**М**онгол Улсын Үндсэн хуулиар «хуульчдаас шүүгчийг шилж олох» чиг үүргийг Ерөнхий зөвлөлд хариуцуулсан. Өмнө нь шүүгчийг шилж олох ажлын хүрээнд голлох буюу шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх чиг үүргийг хэрэгжүүлж байсан бүтэц нь Ерөнхий зөвлөлөөс байгуулдаг Шүүхийн мэргэшлийн хороо байв.

Үндсэн хуулиар хуульчдаас шүүгчийг шилж олох ажлыг Ерөнхий зөвлөлд тусгайлан хариуцуулсан байтал шүүгчид нэр дэвшигчдийг шалгаж, үнэлэх ажлыг Шүүхийн мэргэшлийн хороо (цаашид “Мэргэшлийн хороо” гэх) гэсэн тусдаа бүтцээр гүйцэтгүүлэх шаардлага юунд байсан юм бэ гэх асуулт урган гарч байна. Шинэ Үндсэн хууль хэрэгжиж эхэлсний дараа 1993 оны 02 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан Шүүхийн тухай хуульд тус байгууллагыг хуульчлаагүй. Харин 1994 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулснаар Мэргэшлийн хороог анх Шүүгчийн мэргэшлийн хороо нэртэйгээр байгуулж байжээ.<sup>16</sup> Мэргэшлийн хороог байгуулсан шалтгаан нь Ерөнхий зөвлөл байгуулах, түүний гишүүнийг сонгож, томилохдоо Үндсэн хуулиар тусгайлан хариуцуулсан “хуульчдаас шүүгчийг шилж олох” чиг үүрэгт нь нийцүүлж “шүүгчид нэр

<sup>16</sup> 1993 оны Шүүхийн тухай хуулийн 391 дүгээр зүйлийг үзнэ үү. Мэргэшлийн хороог байгуулах хүртэл хугацаанд Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчдийг үнэлэх чиг үүрэг бүхий комисс байгуулан ажиллуулж байсан байдаг. Тодруулбал, Ерөнхий зөвлөлийн 1993.04.01-ний 13-р “Монгол Улсын шүүгчдийг шалгаруулах журмын тухай дүрэм”-ий баталсан ба уг дүрмийн 13-д “Нэр дэвшигч бүрийн мэргэшлийн түвшинд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс байгуулсан комисс дүгнэлт гаргана”, 14-т “Нэр дэвшигчийн мэргэшлийн түвшинд дүгнэлт гаргах комиссын бүрэлдэхүүнд шүүн таслах, хууль зүйн болон шаардлагатай бусад мэргэжлийн өргөн мэдлэг, дадлагатай, эрдэмтэн, мэргэжилтэн, хуульчдыг оруулна” гэж тус тус заасны дагуу Ерөнхий зөвлөлийн 1994.04.20-ны 15-р тогтоолоор 6 хүний бүрэлдэхүүнтэй комиссыг байгуулсан байдаг.

дэвшигчийг бодитоор үнэлж чадах мэдлэг, ур чадвар, ёс зүйтэй байх” шаардлагыг чухалчилж байгаагүйтэй холбоотой гэж үзэж болно.<sup>17</sup> Тодруулбал, Ерөнхий зөвлөл 2013 он хүртэл статусын хувьд орон тооны бус, зарим гишүүн нь албан тушаалаараа шууд ордог эсхүл улс төрийн институцийн төлөөлөл (Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгчийн зөвлөх, Улсын ерөнхий прокурор) байсан. Ийм учраас шүүгчид нэр дэвшигчийг үнэлэхэд мэргэжлийн мэдлэг, ур чадвар шаардсан уг ажлыг өөр мэргэшсэн бүтцээр гүйцэтгүүлэх шаардлагын хүрээнд Мэргэшлийн хороог байгуулсан байна. Хэдийгээр 2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулиар Ерөнхий зөвлөлийг орон тооны болгосон ч гишүүдийн тоог 5-аар тогтоосноор энэхүү 5 гишүүн шүүхийн захиргааны олон чиг үүргийн хажуугаар шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг хийх бололцоогүй байсан тул шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажлыг Мэргэшлийн хороогоор гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалтыг хэвээр үлдээсэн.

Харин 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Мэргэшлийн хороог халж, шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх чиг үүргийг Ерөнхий зөвлөлийн гишүүдэд өөрт нь шууд хариуцуулсны учир нь Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шүүгч тав, шүүгч бус тав, нийт арван гишүүнтэй байхаар зааж, улмаар 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулиар эдгээр арван гишүүн нь орон тооны байдлаар ажиллахаар заасан тул шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг Ерөнхий зөвлөлийн гишүүд өөрсдөө гүйцэтгэх боломжтой, өөр бүтцээр гүйцэтгүүлэх шаардлагагүй гэж үзсэнийх болов уу.

Хэдийгээр Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.11-д “Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчээс шалгалт авахдаа зохих журмын дагуу хөндлөнгийн хараат бус шинжээчийг оролцуулж болно” гэж заасан боловч хуульд шүүгчийн сонгон шалгаруулалтад хөндлөнгийн шинжээч оролцуулах хүрээ, хязгаарыг тодорхой заагаагүй. Улмаар Ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах

<sup>17</sup> П.Баттулга “Монгол Улсын шүүхийн томилгооны системийг боловсронгуй болгох нь (2020), 7 дахь тал. Legaldata-аас унших боломжтой: <https://legaldata.mn/b/836>

журам”-ын 5.4.2-т “Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтын даалгаврыг боловсруулахдаа тухайн чиглэлээр мэргэшсэн хөндлөнгийн хараат бус шинжээчийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.11 дэх хэсэгт заасны дагуу оролцуулж болно”, 5.4.3-т “Ерөнхий зөвлөлийн гишүүн эрх зүйн тохиолдол шийдвэрлэх, эрх зүйн баримт бичиг боловсруулах, хууль тайлбарлан хэрэглэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргаар авсан шалгалтын хариуг үнэлэхдээ тухайн шалгалтын даалгаврыг зохиосон Ерөнхий зөвлөлийн гишүүн, эсхүл хөндлөнгийн хараат бус шинжээчийн хариулт, аргачлалыг баримтална” гэж заасны дагуу хөндлөнгийн хараат бус шинжээчийг зөвхөн шалгалтын даалгавар боловсруулахад оролцуулж байна.

Гэвч үүнийг зарим нэр дэвшигч эсэргүүцэж Ерөнхий зөвлөлтэй маргаан үүсгэсэн тохиолдол гарсан. Маргаан үүсгэсэн хүмүүс нь Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч байсан бөгөөд тэд Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг шалгахдаа шалгалтын даалгаврын салбар эрх зүйн чиглэлийг сугалаагаар тодорхойлж байгаа нь буруу, мөн хөндлөнгийн хараат бус шинжээчийн боловсруулсан даалгавар, хариулт, үнэлэх аргачлалгүй шалгалтуудыг хэн хэрхэн үнэлэх, нэр дэвшигч нарын гүйцэтгэсэн даалгаврыг үнэлэхэд тухайн салбарын мэргэшсэн шинжээчийг оролцуулахгүй байгаа нь буруу гэж үзсэн. Шалгалтын даалгаврын салбар эрх зүйн чиглэлийг сугалаагаар тодорхойлж байгаа нь буруу гэж үзсэн асуудлыг судалгааны дараагийн хэсэгт дэлгэрүүлэн авч үзнэ.

*Хүснэгт 4. С.М, Д.Х-ийн нэхэмжлэлтэй Ерөнхий зөвлөлд холбогдох захиргааны хэрэг<sup>18</sup>*

**Нэхэмжлэлийн шаардлага:**

1. “Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 57 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ын 5.3.1.2, 5.3.1.3-т “Салбар эрх зүйн чиглэлийг нийт нэр дэвшигчийн нэг төлөөлөл сугалаагаар тодорхойлно” гэж тус тус заасныг хүчингүй болгуулах,
2. Уг журмаар хөндлөнгийн хараат бус шинжээчийн боловсруулсан даалгавар, хариулт, үнэлэх аргачлалгүй шалгалтуудыг хэн хэрхэн үнэлэх, нэр дэвшигч нарын гүйцэтгэсэн даалгаврыг үнэлэхэд тухайн салбарын мэргэшсэн шинжээчийг оролцуулах зэрэг зохицуулах ёстой хуульд заасан харилцааг зохицуулаагүй орхисныг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.12, 72 дугаар зүйлийн 72.1.5-д заасныг зөрчсөн болохыг тогтоож, уг хуульд заасан зохицуулах ёстой харилцааг бүрэн зохицуулахыг Шүүхийн ерөнхий зөвлөлд даалгах”

**Нэхэмжлэлийн үндэслэл:** “... Журмын 5.4.2-т “Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтын даалгаврыг боловсруулахдаа тухайн чиглэлээр мэргэшсэн хөндлөнгийн хараат бус шинжээчийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.11 дэх хэсэгт заасны дагуу оролцуулж болно” гэж заасан нь тухайн чиглэлээр мэргэшсэн хөндлөнгийн хараат бус шинжээч нь зөвхөн даалгавар боловсруулахад оролцож, харин даалгаврыг үнэлэхэд тухайн салбарын мэргэшсэн этгээдийг оролцуулахгүй байгаа нь хуулийн зорилго, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 34.3-т “Хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт нь нэр дэвшигчийг урьдчилан мэдэх боломжгүй, хөндлөнгийн байдлаар үнэлэх нөхцөлийг хангасан байх ...-ыг” гэж заасантай нийцэхгүй байна.

Хэдийгээр 5.4.3-т “Ерөнхий зөвлөлийн гишүүн эрх зүйн тохиолдол шийдвэрлэх, эрх зүйн баримт бичиг боловсруулах, хууль тайлбарлан хэрэглэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргаар авсан шалгалтын хариуг үнэлэхдээ тухайн шалгалтын даалгаврыг зохиосон Ерөнхий зөвлөлийн гишүүн, эсхүл хөндлөнгийн хараат бус шинжээчийн хариулт, аргачлалыг баримтална” гэж заасан боловч ямар нэгэн даалгаврын дагуу авдаггүй, шинжээчийн хариултгүй зарим даалгаврын тухайд шууд тухайн салбараар мэргэшээгүй Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүд өөрсдөө үнэлж байгаа нь Шүүхийн тухай хуульд заасан журам батлах эрх олгосон хүрээнээс болон мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7-д заасан хуулиар олгосон эрхээс хэтэрсэн байна.”


**Хариуцагчийн тайлбар:** “... Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ын 5.4.2-т зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүгч сонгон шалгаруулахдаа нэр дэвшигчийн шалгалтын даалгавар, тухайн даалгаврын хариу буюу түлхүүрийг тухайн чиглэлээр мэргэшсэн хөндлөнгийн хараат бус шинжээчээр боловсруулуулдаг бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл нэр дэвшигчдийн шалгалтын материалыг түүнд нийцүүлэн үнэлж байгаа бөгөөд шалгалтын түлхүүрээс өөрөөр үнэлэх боломжгүй юм.”

<sup>18</sup> Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал. 2025.06.30, Дугаар 0017 [https://shuukh.mn/single\\_case/9040?daterange=2025-01-01%20-%202025-09-19&id=2&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/9040?daterange=2025-01-01%20-%202025-09-19&id=2&court_cat=3&bb=1) (Сүүлд 2025.09.15-ны өдөр хандсан)


**Шүүхийн шийдвэрийн үндэслэл:** "... нэхэмжлэлийн 2 дахь шаардлагын хүрээнд Шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.11 дэх хэсгийн "Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчээс шалгалт авахдаа зохих журмын дагуу хөндлөнгийн хараат бус шинжээчийг оролцуулж болно" гэснийг одоогийн маргаан бүхий журмын 5.4.2-т зөвхөн шалгалтын даалгавар боловсруулахад л хэрэглэхээр зохицуулсан нь хангалтгүй, түүнчлэн "...ямар нэгэн даалгаврын дагуу авдаггүй, шинжээчийн хариултгүй зарим шалгалтын тухайд тухайн салбараар мэргэшээгүй Зөвлөлийн гишүүд өөрсдөө үнэлж байгаа нь хуулиар олгогдсон эрхээс хэтэрч байна..." гэснийг үндэслэлгүй гэж үзлээ. Учир нь журмын 5.4.2-т "Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтын даалгаврыг боловсруулахдаа тухайн чиглэлээр мэргэшсэн хөндлөнгийн хараат бус шинжээчийг оролцуулж болох"-оор заасан, бодит байдалд ч энэ хүрээнд бичгийн шалгалтын даалгавар, үнэлэх аргачлалыг боловсруулуулж хэрэгжүүлж байгаа нь дээрх хуулийн 34.11-т заасантай нийцсэн, харин хөндлөнгийн шинжээчээр шалгалтын үнэлгээ хийлгэж болохоор журамлахыг шүүхээс даалгах нь хуулиар олгогдсон Ерөнхий зөвлөлийн бүрэн эрхэд халдах үр дагавартай" гэжээ.

Дээрх маргаанаас үзэхэд нэхэмжлэгч нар шүүгчид нэр дэвшигчийг эрх зүйн салбараар мэргэшээгүй Ерөнхий зөвлөлийн гишүүн үнэлж байгаа нь буруу гэсэн байна.

**Асуумж:** Судалгааны хүрээнд "Ерөнхий зөвлөлийн гишүүд нь шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг үнэлэх хангалттай хууль зүйн мэдлэг, ур чадварыг эзэмшсэн эсэх" талаар асуумж авахад 34 оролцогч Ерөнхий зөвлөлийн гишүүд шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг үнэлэх хангалттай хууль зүйн мэдлэг, ур чадвартай гэж үзээгүй нь асуумжийн доорх үр дүнгээс харагдаж байна.



Мөн асуулгад оролцогчид Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадварыг үнэлэхдээ мэргэшсэн этгээд (бүрэлдэхүүн)-ийг оролцуулах эрх зүйн зохицуулалт байх хэрэгтэй гэж үзсэн байна.



2025 оны 10 дугаар сарын 09, 10-нд болсон Нийт шүүгчийн III чуулганаар “Шүүгчдийн сонгон шалгаруулалтад оролцогчдын хууль зүйн мэдлэг, чадварыг үнэлэх чиг үүрэг бүхий бүтэц (институци)-ийг Монгол Улсын шүүхийн тухай хуульд оруулах” гэсэн саналыг шүүгчид баталсан.<sup>19</sup>

Одоо Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүнээр анхан болон давж заалдах шатны шүүхээс тус бүр 2 шүүгч, Дээд шүүхийн 1 шүүгч сонгогддог, мөн одоо ажиллаж байгаа Ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүдийн ажлын байдал, төлөөллийг авч үзвэл шүүхийн захиргааны байгууллага, өмгөөлөгч, хуулийн салбарын эрдэмтэн, нотариатч, төрийн захиргааны албан хаагч зэрэг хүн тус тус томилогдсон байна. Ерөнхий зөвлөлийн гишүүдийг сонгох, томилохдоо мэргэшсэн байдал, салбар эрх зүйн чиглэлийн тэнцвэр зэргийг харгалзан үздэггүй нь улмаар Ерөнхий зөвлөлийн гишүүдийн шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх мэдлэг, чадвар, мэргэшсэн байдалд эргэлзэхэд хүргэж байж болох талтай. Тэгвэл Мэргэшлийн хороо нь орон тооны бус есөн гишүүнээс буюу тэдгээрийн зургаа нь шүүгч, гурав нь хууль зүйн эрдэмтдээс бүрдэж байсан. Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд “хууль зүйн өндөр мэргэшилтэй, хууль зүйн болон шүүн таслах ажлын туршлагатай, шүүгч, хуульч, эрдэмтэн байх” гэсэн шаардлагыг хуулиар тавьж байсан.<sup>20</sup> Энэ хүрээнд Ерөнхий зөвлөл Мэргэшлийн хорооны

<sup>19</sup> [https://www.judcouncil.mn/site/news\\_full/15426](https://www.judcouncil.mn/site/news_full/15426)

<sup>20</sup> Шүүхийн тухай хууль (2002 он): §30.3.Мэргэшлийн хороо нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хуулийн болон шүүн таслах ажлын дадлагатай шүүгч, хуульч, эрдэмтдээс бүрдэнэ. Шүүхийн захиргааны тухай хууль (2012 он): §23.3.Мэргэшлийн хороо нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хууль зүйн болон шүүн таслах ажлын туршлагатай, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан шүүгч, хуульчаас бүрдэх бөгөөд Хуульчдын холбооноос санал болгосноор Ерөнхий зөвлөл Мэргэшлийн хороог байгуулна.

бүрэлдэхүүнд давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгч, хууль зүйн салбарын эрдэмтэн, судлаачдын төлөөллийг салбар эрх зүйн чиглэл (үндсэн хууль, эрүү, иргэн, захиргааны зэрэг)-ийг нь харгалзан тэнцвэртэйгээр оруулах бодлогыг баримталж байсан нь Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүний томилгооноос харагддаг. Ерөнхий зөвлөл ба Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнийг байдлыг дараах хүснэгтэд харьцуулан үзвэл:

*Хүснэгт 5. Мэргэшлийн хороо ба Ерөнхий зөвлөлийн ялгаа*

Мэргэшлийн хороо	Ерөнхий зөвлөл
Мэргэшлийн хорооны 6 шүүгч гишүүнийн дийлэнх нь хяналтын шатны шүүхийн шүүгч, нэг эсхүл хоёр нь давж заалдах шатны шүүхийн шүүгч ордог.	Ерөнхий зөвлөлийн шүүгч таван гишүүний олонх нь дөрөв нь анхан, давж заалдах шатны шүүхийн шүүгч, нэг нь хяналт шатны шүүхийн шүүгч байна.
Мэргэшлийн хорооны шүүгч бус гишүүн нь хууль зүйн эрдэмтэн байна.	Ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд ийм шаардлагыг хуулиар тавиагүй ба нээлттэйгээр нэр дэвшүүлж УИХ-аас томилж байгаа тул хууль зүйн эрдэмтэн орохгүй байх боломжтой
Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүн нь салбар эрх зүйн чиглэл (үндсэн хууль, эрүү, иргэн, захиргааны зэрэг)-ийн төлөөлөл бүхий тэнцвэртэй бүрэлдэхүүнтэй.	Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүд нь нийт шүүгчийн чуулганаас сонгогддог, шүүгч бус гишүүдийг нээлттэйгээр нэр дэвшүүлж УИХ-аас томилдог тул салбар эрх зүйн төлөөллийг тэнцвэрийг хангах боломжгүй.

Дээрхээс үзэхэд шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг үнэлэхэд илүү мэргэшсэн бүрэлдэхүүнтэй байх шаардлагад Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүн нийцэж байна. Иймд Мэргэшлийн хороог байгуулж шүүгчийн сонгон шалгаруулалтад нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадварыг шалгах, үнэлэх үе шатанд оролцуулах, Мэргэшлийн хорооны шалгалтаар тэнцсэн нэр дэвшигчийн ёс зүй, зан төлөвийг Ерөнхий зөвлөл үнэлдэг байх нь зүйтэй. Харин Мэргэшлийн хороог Ерөнхий зөвлөлийн шийдвэрээр байгуулснаар Мэргэшлийн хорооны шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг үнэлэх чиг үүрэг нь Ерөнхий зөвлөлийн Үндсэн хуулиар хүлээсэн “шүүгчийг шилж олох” чиг үүрэгтэй зөрчилдөхгүй юм.

## Тав. Шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх арга, хэлбэр

**Ш**үүгчийн сонгон шалгаруулалтад шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх арга, хэлбэр чухал бөгөөд энэ нь хууль зүйн өндөр мэдлэгтэй, шүүгчийн хараат бус байдлыг хадгалж, хэн нэгний нөлөөнд авталгүйгээр хэрэг, маргааныг хуулийн дагуу шударгаар шийдвэрлэх ёс зүй, зан төлөвтэй хүнийг олж шүүгчээр томилоход чиглэнэ.

### 5.1. Шүүгчид нэр дэвшигчийг хууль зүйн мэдлэг, чадварыг үнэлэх нь

Монгол Улс өнгөрсөн хугацаанд шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг шалгахдаа нэг удаагийн бичгийн шалгалт (сорил бөглөх, тохиолдол шийдвэрлэх, баримт бичиг боловсруулах г.м)-ыг гол болгосоор иржээ.

2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 165 дугаар зарлигаар батлагдсан “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-аар давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг үнэлэх шалгуурт шийдвэрийн чанар<sup>21</sup>, мэргэжлийн үйл ажиллагааны түвшин<sup>22</sup>-г оруулсан байсан боловч шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг үнэлэхтэй холбоотой Шүүгчийн эрх зүйн

<sup>21</sup> Нэр дэвшигч анхан шатны шүүхийн шүүгчээр ажиллах хугацаанд дангаар шийдвэрлэсэн 6 хүртэлх хэрэг, маргааны шийдвэрийг тохиолдлын журмаар сонгон авч, тухайн хэрэг, маргааныг холбогдох эрх зүйн эх сурвалжийг тайлбарлан хэрэглэж, тодорхой, ойлгомжтой шийдвэрлэсэн эсэхийг задлан шинжилж, дүгнэнэ;

<sup>22</sup> Нэр дэвшигчийн анхан шатны шүүхийн шүүгчээр ажилласан сүүлийн 24 сарын хугацаанд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заасны дагуу үнэлүүлсэн мэргэжлийн үйл ажиллагааны түвшингийн дүнг хувилж 30 хүртэлх оноогоор дүгнэнэ.

байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хуулийн заалтыг Үндсэн хуулийн цэцээс хүчингүй болгосноор хэрэгжиж чадаагүй.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д “Шүүгчид нэр дэвшигчийн шалгалт нь хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтаас бүрдэнэ” гэж заасан. Шалгалтын арга, хэлбэрийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-аар нарийвчлан зохицуулсан байх бөгөөд шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг дараах аргаар шалгаж дүгнэхээр заажээ.

*Хүснэгт 6. Хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтын арга*

Нэр дэвшигч	1	2	3	3	5
Анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигч	Үндсэн хуулийн эрх зүйн мэдлэгийн сорилын асуултад хариулах (15 хүртэл оноо)	Эрх зүйн баримт бичиг боловсруулах (15 хүртэл оноо)	Эрх зүйн тохиолдол шийдвэрлэх (25 хүртэл оноо)	Салбар эрх зүйн мэдлэгийн сорилын асуултад хариулах (15 хүртэл оноо)	
Давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигч	Эрх зүйн баримт бичиг боловсруулах (15 хүртэл оноо)	Эрх зүйн тохиолдол шийдвэрлэх (25 хүртэл оноо)	Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх (20 хүртэл оноо)	Салбар эрх зүйн мэдлэгийн сорилын асуултад хариулах (10 хүртэл оноо)	
Хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигч	Үндсэн хуулийн эрх зүйн мэдлэгийн тохиолдол шийдвэрлэх (10 хүртэл оноо)	Хууль тайлбарлах (15 хүртэл оноо)	Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх (15 хүртэл оноо)	Эрх зүйн тохиолдол шийдвэрлэх (15 хүртэл оноо)	Хэрэг, маргааныг хяналтын журмаар болон бусад асуудлыг хянан шийдвэрлэх мэдлэгийн сорилын асуултад хариулах (15 хүртэл оноо)

Дээрхээс үзэхэд шүүхийн шатлал хамаарахгүйгээр анхан, давах, хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг нэг удаагийн бичгийн шалгалтаар үнэлэх арга, хэлбэрийг ашиглаж байна.

*Хүснэгт 7. Есөн удаагийн сонгон шалгаруулалтад хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад тэнцсэн нэр дэвшигч<sup>23</sup>*

	Шүүхийн шатлал	Зарласан сул орон тоо /нийт/	Шүүх	Зарласан сул орон тоо	Нэрээ дэвшүүлсэн хуульчийн тоо	Бүртгэсэн байдал		Тэнцсэн нэр дэвшигчийн тоо	Хувь
						Бүртгэсэн	таггалзсан		
1.	Анхан шатны шүүх	331	Эрүүгийн хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх	51	402	305	97	30	9.84
2.			Иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх	180	524	389	135	31	7.97
3.			Эрүү, иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх	69	184	148	36	1	0.68
4.			Захиргааны хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх	31	202	158	44	22	13.92
5.	Давж заалдах шатны шүүх	98	Эрүүгийн хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх	15	45	36	9	23	63.89
6.			Иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх	22	81	73	8	36	49.32
7.			Эрүү, иргэний хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх	49	62	49	13	22	44.90
8.			Захиргааны хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх	12	31	29	2	11	37.93
9.	Хяналтын шатны шүүх	14	Монгол Улсын дээд шүүх	14	45	39	6	9	23.08
<b>НИЙТ</b>			<b>443</b>		<b>1576</b>	<b>1226</b>	<b>350</b>	<b>185</b>	<b>15.09</b>

<sup>23</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлөөс авсан тоон мэдээлэл

Дээрх тоон мэдээллээс үзэхэд, давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчдийн хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад тэнцэх хувь харьцангуй өндөр байгаа бол, хяналтын шат, анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчдийн хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад тэнцсэн хувь бага байна. Ялангуяа анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчдийн хууль зүйн, мэдлэг чадвар шалгалтад тэнцэх хувь хангалтгүй байгаа нь мэдлэг, чадвартай хуульчид шүүгчид нэр дэвшихгүй байгаа гэх шалтгаан байх боломжтой ч, нөгөө талаас шүүгчид нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагаас үзэхэд шүүгчийн нэр дэвшигчийн шалгалтад бэлтгэх үндэслэл, удирдамж байдаггүй явдал нөлөөлж байж болох юм.

**Шүүгчид нэр дэвшигч:** “Миний хувьд Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгчийн сул орон тоонд анх удаа шүүгчийн шалгалт өгсөн бөгөөд аль эх сурвалжаас шалгалтдаа бэлдэх заавар, удирдамж байдаггүй нь бэрхшээлтэй байсан. 2022 онд хэвлүүлсэн Шүүгчийн сонгон шалгаруулалтын даалгаврын эмхэтгэлийг л уншсан. Энэ шалгалтад ороод шүүгчийн шалгалтыг ийм байдлаар авдаг юм байна гэсэн төсөөлөлтэй болсон.

**Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагаас**

#### *А. Шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварын үнэлэх арга, хэлбэрийг өөрчлөх шаардлага*

Судалгааны өмнөх хэсэгт дурдсанчлан Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг шалгахдаа шалгалтын даалгаврын салбар эрх зүйн чиглэлийг сугалаагаар тодорхойлж байгааг буруу гэж маргаан үүсгэж, шүүхээр шийдвэрлүүлсэн байна.

**Маргааны агуулга:** 1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 57 дугаар тогтоолоор батлагдсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ын 5.3.1.2-т “хууль тайлбарлах мэдлэг, чадварыг хууль тайлбарлан хэрэглэх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 15 хүртэл оноогоор үнэлэх. Нэр дэвшигч аль салбар эрх зүйн чиглэлээр хууль тайлбарлахаа сонгоно;”, -5.3.1.3-т “шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх чадварыг анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд дүн шинжилгээ хийх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 15 хүртэл оноогоор үнэлэх.

Нэр дэвшигч аль салбар эрх зүйн чиглэлээр шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхээ сонгоно;" гэж зохицуулсны тус тус "...Нэр дэвшигч аль салбар эрх зүйн чиглэлээр хууль тайлбарлах, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхээ сонгоно гэснийг 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 198 дугаар тогтоолоор "...Салбар эрх зүйн чиглэлийг нийт нэр дэвшигчийн нэг төлөөлөл сугалаагаар тодорхойлно" гэж өөрчилсөн.

**Нэхэмжлэлийн шаардлага:**

1. "Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 57 дугаар тогтоолоор баталсан "Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам"-ын 5.3.1.2, 5.3.1.3-т "Салбар эрх зүйн чиглэлийг нийт нэр дэвшигчийн нэг төлөөлөл сугалаагаар тодорхойлно" гэж тус тус заасныг хүчингүй болгуулах,
2. Уг журмаар хөндлөнгийн хараат бус шинжээчийн боловсруулсан даалгавар, хариулт, үнэлэх аргачлалгүй шалгалтуудыг хэн хэрхэн үнэлэх, нэр дэвшигч нарын гүйцэтгэсэн даалгаврыг үнэлэхэд тухайн салбарын мэргэшсэн шинжээчийг оролцуулах зэрэг зохицуулах ёстой хуульд заасан харилцааг зохицуулаагүй орхисныг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.12, 72 дугаар зүйлийн 72.1.5-д заасныг зөрчсөн болохыг тогтоож, уг хуульд заасан зохицуулах ёстой харилцааг бүрэн зохицуулахыг Шүүхийн ерөнхий зөвлөлд даалгах"

**Нэхэмжлэлийн үндэслэл:** "... шүүхийн дээд байгууллага болох Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчийг хуульчдын дундаас шилж олохдоо сугалаагаар эрх зүйн нэг салбарын даалгавраар шалгах нь тэдний мэдлэг чадварыг бодитой, шударгаар өрсөлдүүлэн шалгаруулж, хамгийн сайн үнэлэгдсэн хуульчийг шилж олж, хяналтын шатны шүүхийн шүүгчээр томилуулахаар нэр дэвшүүлэх зорилгодоо нийцэхгүй байна. Шүүхийн харьяалан шийдвэрлэх хэрэг, эрх зүйн маргааны төрлөөр эрүү, иргэн, захиргааны хэргийн дагнасан шүүх үйл ажиллагаа явуулж, шүүгч нар дагнан мэргэшиж ажиллаад 20 жил болж байна. .. Гэтэл салбар эрх зүйн шалгалтын даалгаврууд сугалаагаар сонгогдсоноор нэг салбарт мэргэшсэн нэр дэвшигч нөгөө салбарын даалгавар гүйцэтгэх нь тухайн салбараар мэргэшсэн нэр дэвшигчтэй тэгш, шударгаар өрсөлдөх боломжгүйд хүргэж байна. Мөн зөвхөн сугалагдсан салбараар шалгалт өгөх нь нөгөө салбарын мэдлэг чадварын шаардлага хангах эсэхийг тодорхойлж чадахгүй, өөрөөр хэлбэл энэхүү өөрчлөлт оруулах болсон зорилгыг Улсын Дээд шүүхийн шүүгч нар эрүү, иргэн, захиргааны аль ч танхимд ажиллах боломжтой байх, мөн Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд оролцож хуульд заасан асуудлыг шийдвэрлэхэд оролцдог учраас ийнхүү өөрчлөлт оруулсан гэж үзвэл энэ зорилго огт хангагдахааргүй байна."

**Хариуцагчийн тайлбар:** "Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.5 дахь заалтаар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд "Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам"-ыг 2022 оны 57 дугаар тогтоолоор баталсан. ... журмыг батлан гаргахаас өмнө иргэд, олон нийт, эрх ашиг нь хөндөгдөх бүлгээс санал авч боловсруулсан ба нэхэмжлэгчийн нэхэмжлэлд дурдсан журмын холбогдох заалтыг хүчингүй болгуулах талаар санал ирээгүй болно."

**Шүүхийн шийдвэрийн үндэслэл:** "... Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан журмыг хэлэлцсэн мөн оны 3 дугаар сарын 10-ны өдрийн болон тус журамд өөрчлөлт оруулсан 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээс тус тус үзэхэд Улсын дээд шүүхийн шүүгч танхим сэлгэж хэрэг маргааныг хянан шийдвэрлэх хэрэгцээ шаардлага үүссэнтэй, мөн Улсын Дээд шүүхээс сул орон тооны захиалгыг анх танхим зааж ирүүлдэг байсныг өөрчилж, "Улсын дээд шүүхийн шүүгч" гэж ирүүлж байгаатай холбогдуулан нэр дэвшигчдийн мэдлэг чадварыг хэрхэн, ямар хэлбэрээр шалгаруулж болох талаар

Зөвлөлийн гишүүдээс олон янзын санал гаргаж байсан ч эцсийн байдлаар хууль тайлбарлах мэдлэг, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх чадварыг эрх зүйн аль салбараар дүгнүүлэхээ зөвхөн “сугалаа”-аар сонгохоор журамласан нь тухайн нэр дэвшигчийн мэдлэг чадварыг шалгах, үнэлэх оновчтой арга биш, өөрөөр хэлбэл сугалагдсан салбар эрх зүйн чиглэлээр шалгалт өгсөн нь сугалагдаагүй үлдсэн салбар эрх зүйн талаарх нэр дэвшигчийн мэдлэг чадварыг үнэлсэн гэж үзэх үндэслэл болохгүй бөгөөд энэ нь хууль зүйн төдийгүй энгийн ухамсрын түвшинд ч ойлгомжгүй зохицуулалт болно. ... салбар эрх зүйн бичгийн шалгалтын даалгаврыг ийнхүү сугалаагаар сонгохоор зохицуулсан нь өөр өөр салбараар мэргэшсэн нэр дэвшигчдийг тэгш, шударгаар өрсөлдөх боломжгүйд хүргэж болохоор байна” гэжээ.

Дээрх маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хэлэлцээд “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ын 5.3.1.2, 5.3.1.3-т “...Салбар эрх зүйн чиглэлийг нийт нэр дэвшигчийн нэг төлөөлөл сугалаагаар тодорхойлно” гэснийг тус тус хариуцагчаас дахин шинээр захиргааны акт гаргатал нэг сарын хугацаагаар түдгэлзүүлж” шийдвэрлэсэн.<sup>24</sup> Уг маргааны дагуу Ерөнхий зөвлөлөөс дээрх журамд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.<sup>25</sup>


#### *Хүснэгт 8. Өмнөх заалт болох өөрчилсөн хувилбарын харьцуулалт*

Журмын өмнөх заалт	Өөрчилсөн хувилбар
<p>“Хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт дараах төрөл, арга, хугацаа, үнэлэх оноотой байна:</p> <p>5.3.1.2. хууль тайлбарлах мэдлэг, чадварыг хууль тайлбарлан хэрэглэх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 15 хүртэл оноогоор үнэлэх. Салбар эрх зүйн чиглэлийг нийт нэр дэвшигчийн нэг төлөөлөл сугалаагаар тодорхойлно.</p> <p>5.3.1.3. шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх чадварыг анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд дүн шинжилгээ хийх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 15 хүртэл оноогоор үнэлэх. Салбар эрх зүйн чиглэлийг нийт нэр дэвшигчийн нэг төлөөлөл сугалаагаар тодорхойлно.</p>	<p>5.3.1.2. Нэр дэвшигч журмын 5.3.1.4-т сонгосон салбар эрх зүйтэй давхцахгүйгээр өөрөө сонгож шалгалт өгнө.</p> <p>“5.3.1.3. Нэр дэвшигч журмын 5.3.1.2, 5.3.1.4-т сонгосон салбар эрх зүйтэй давхцахгүйгээр салбар эрх зүйгээр шалгалт өгнө.</p>

**Асуумж.** Шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг шалгаж буй арга хэлбэр, шалгуур нь тохиромжтой эсэх буюу хамгийн сайн шүүгчийг шилж олох зорилгод нийцэж байгаа эсэх?

<sup>24</sup> Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 0017 дугаартай магадлалтай захиргааны хэрэг. [https://shuukh.mn/single\\_case/9040?daterange=2025-01-01%20-%202025-09-19&id=2&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/9040?daterange=2025-01-01%20-%202025-09-19&id=2&court_cat=3&bb=1) (Сүүлд 2025.09.15-ны өдөр хандсан)

<sup>25</sup> [https://www.judcouncil.mn/site/news\\_full/15314](https://www.judcouncil.mn/site/news_full/15314)



Асуулгын үр дүнгээс үзэхэд, оролцогчдын олонх нь анхан, давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг шалгаж буй арга хэлбэр, шалгуурын тохиромжтой байдлыг “дунд зэрэг” гэж, хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг шалгаж буй арга хэлбэр, шалгуурыг олонх нь “муу”, “дунд” гэж үзжээ.

Одоогийн эрх зүйн зохицуулалтаар анхан шатны шүүхийн шүүгчээр 6-аас доошгүй жил ажилласан шүүгч давж заалдах шатны шүүхийн шүүгч болох боломжтой. Тухайн шүүгч 6 жилийн турш шүүгчээр ажиллахдаа хэдэн мянган цаг ажиллаж, хэдэн зуун хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, хэдэн зуун шийдвэр бичсэн гэсэн үг учир дээд шатны шүүхэд ажиллахаар өгөх шалгалт нь тухайн шүүгчийн өгөх хамгийн бодитой “шалгалт” юм. Иймд нэг, хоёр өдрийн бичгийн шалгалт түүний 6 жилийн ажлыг бүрэн үнэлэх үнэлэмж болно гэхэд тун эргэлзээтэй. Мөн 10 жил ажилласан шүүгч Улсын дээд шүүхэд нэр дэвших боломжтой тул мөн адил асуудал үүснэ.

Угтаа шүүгчийн хувьд аль хэдийн байгаа объектив өгөгдөл нь бичгийн шалгалтаас илүү тухайн хүний талаар чанартай мэдээлэл өгөх боломжтой. Үүнд, тухайлбал хэрэг шийдвэрлэлтийн хувь (Clearance rates), шүүхийн шийдвэрийн чанар, бичиж нийтлүүлсэн илтгэл, өгүүлэл зэргийг судлах аргыг нэвтрүүлж болох юм. Хэрэг шийдвэрлэлтийн хувь (Clearance rates) нь тухайн тайлант онд шийдвэрлэсэн хэргийн тоо ба тухайн онд шинээр үүсгэсэн буюу хүлээж авсан хэргийн тооны харьцаа илтгэх үзүүлэлт бөгөөд үүнийг Ерөнхий зөвлөл шүүгч нэр дэвшигч дээр

гаргах боломжтой тоон мэдээлэл юм.<sup>26</sup> Шүүхийн шийдвэрийн чанарын хүрээнд хувь шүүгчийн дангаар гаргасан шүүхийн шийдвэрийн дээд шатны шүүхээр хянагдаж хүчингүй болсон, өөрчлөлт орсон хувь, эсхүл тодорхой тооны шүүхийн шийдвэр<sup>27</sup>, бичсэн өгүүлэл, нийтлэлийг судалж тухайн шүүгчийн хууль тайлбарлан хэрэглэх, бичих, илэрхийлэх чадварыг үнэлж болно. Шүүхийн шийдвэрийн чанарын хүрээнд хүчингүй болсон болон хэвээр үлдсэн шүүхийн шийдвэрүүдийн аль алиныг нь авч судалж болно. Улсын дээд шүүхэд прокурор, өмгөөлөгч, хууль зүйн сургуулийн багш нэр дэвших боломжтой тул тэдгээрээс авах нийтлэг шалгалт байхаас гадна нэр дэвшигчийн төрөл тус бүрд тохирсон хууль зүйн мэдлэг, чадварыг нь үнэлэх аргыг тодорхойлж болно.

Нэг удаагийн бичгийн шалгалт нь “хамгийн муу”-г хасахад тус болж болох ч “хамгийн сайныг” олоход хангалтгүй бөгөөд ялангуяа одоо ажиллаж байгаа шүүгч дээд шатны шүүхэд нэр дэвшиж байгаа тохиолдолд тохиромжгүй арга юм. Өөрөөр хэлбэл, анх удаа шүүгч болох гэж байгаа хүнийг “чадах эсэх”-ийг нь, шүүгч дээд шатны шүүгч болох гэж байгаа бол “чадсан эсэх”-ийг нь харах ёстой гэсэн үг. Тодруулбал, анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг нэг удаагийн бичгийн шалгалтаар үнэлэх нь тохиромжтой бол дээд шатны шүүхэд нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг нэг удаагийн бичгийн шалгалтаар үнэлэх нь тохиромжгүй байна. Дараах хэсэгт Канадын дээд шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтын туршлагыг товч авч үзье.

### *Б. Канад Улсын дээд шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтын туршлага*

Канадын дээд шүүх нь 9 шүүгчээс бүрдэнэ. Дээд шүүхийн шүүгчээр мужийн дээд шүүхийн шүүгч, эсхүл мужийн хуульчдын холбооны гишүүнчлэлтэй арваас доошгүй жил ажилласан өмгөөлөгчийг томилж болно. Дээд шүүхийн шүүгчийг Ерөнхий сайдаас зөвлөмж болгосноор

<sup>26</sup> Монгол Улсын шүүхийн индексийг гаргахдаа Clearance rates -ийг нэг шалгуур үзүүлэлт болгож шүүхийн хэмжээнд тооцож гаргаж байна. <https://judindex.forum.mn/>

<sup>27</sup> Энэ тохиолдолд нэр дэвшигчийн гаргасан шүүхийн шийдвэрүүдээс тохиолдлын журмаар сонгох бус харин нэр дэвшигчээс өөрөөр нь хамгийн сайн бичсэн шүүхийн шийдвэрийг нь тодорхойлуулах нь оновчтой.

Канадын Амбан захирагч томилдог. 2016 оноос хойш Хараат бус Зөвлөх зөвлөл (Independent Advisory Board)-ийн удирдлага дор ил тод, мерит зарчимд суурилсан байдлаар явуулж байна. Тус Зөвлөх зөвлөл нь 8 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Канадын Ерөнхий сайд 5 жилийн хугацаагаар томилж, улмаар улируулан томилж болно:

- а) Хууль зүйн сайдын санал болгосон гурван хүн, үүний хоёроос доошгүй нь өмгөөлөгч биш байх;
- б) Канадын Өмгөөлөгчдийн холбооноос санал болгосон холбооны гишүүн;
- в) Канадын Хууль зүйн нийгэмлэгүүдийн холбооноос санал болгосон холбооны гишүүн;
- г) Уугуул иргэдийн Өмгөөлөгчдийн холбооноос санал болгосон холбооны гишүүн;
- д) Канадын Шүүхийн зөвлөлөөс санал болгосон тэтгэвэрт гарсан дээд шатны шүүхийн шүүгч;
- е) Канадын хуулийн сургуулийн захирлуудын зөвлөлөөс санал болгосон хууль зүйн профессор.

Хараат бус Зөвлөх зөвлөл (Зөвлөх зөвлөл) Канадын Дээд шүүхийн томилгооны талаар Ерөнхий сайдад мерит зарчимд суурилсан зөвлөмж (заавал дагах шинжгүй) өгөх үүрэгтэй. Зөвлөх зөвлөл нь нэр дэвшигч тус бүр Дээд шүүхийн тухай хуульд заасан шаардлага болон Ерөнхий сайдын тогтоосон шалгуурыг хангаж байгаа эсэх, мөн нэр дэвшүүлэхийг дэмжсэн нэмэлт үндэслэлийн талаарх үнэлгээг гаргаж өгөх ёстой. Канадын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх шалгуурыг хувийн, мэргэжлийн гэж хоёр ангилна:<sup>28</sup>

#### Хувийн ур чадвар, туршлага

- Хууль зүйн өндөр мэдлэгтэй байх
- Аналитик (дүн шинжилгээ хийх) ур чадвар өндөр байх
- Хууль зүйн ээдрээ төвөгтэй асуудлыг шийдвэрлэх чадвартай байх
- Хууль зүйн маргаан үүсэж буй нийгмийн орчин, нөхцөлийг ухамсарлаж, түүнтэй холбоотой мэдээллийг нэгтгэн дүгнэж

<sup>28</sup> <https://www.fja-cmf.gc.ca/scc-csc/2023/qualifications-eng.html>

чаддаг байх<sup>29</sup>

- Бодол, дүгнэлтээ бичгээр илэрхийлэх чадвартай байх
- Давчууцаг хугацаанд аль ч салбар эрх зүйн хүрээнд их хэмжээний баримт бичиг, хэргийн материалтай ажиллах чадвартай байх
- Олон нийтийн үйл хэрэгт үнэнч, тууштай байх

#### Хувийн зан чанар

- Хувийн болон мэргэжлийн хувьд шударга байх
- Бусдыг хүндлэх, анхаарал тавих
- Хүний ялгаатай үзэл бодол, хандлага, амьдралын туршлагыг ойлгож, хүндэтгэн хүлээж авах чадвартай байх
- Биеэ зөв, ёс зүйтэй авч явах
- Ёс суртахууныг эрхэмлэх зоригтой байх<sup>30</sup>
- Нээлттэй сэтгэлгээтэй байх

2023 онд зохион байгуулсан Дээд шүүхийн шүүгчийн томилгооны процессын нарийвчилсан тайланд үндэслэн Канадын шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх арга, хэлбэрийг авч үзье.<sup>31</sup> Нэр дэвшигч боловсрол, туршлагынхаа талаар дэлгэрэнгүй танилцуулга<sup>32</sup> өгөх бөгөөд үүндээ дараах материалыг хавсаргана:

- Дүн шинжилгээ хийх, хууль зүйн нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэх, хууль зүйн бичгийн ур чадвараа харуулсан шүүхийн шийдвэр, хууль зүйн баримт бичиг (factum<sup>33</sup>), нийтлэл зэрэг 5 баримт бичиг, тэдгээрийн тухай тус бүрийн тойм, яагаад сонгосон шалтгаанаа 300 үгэнд багтааж бичнэ.<sup>34</sup>

<sup>29</sup> Шүүгч нь маргаан үүсгэж буй нийгмийн асуудлыг мэддэг, сонирхон ханддаг, нийгмийн үнэт зүйлсийн өөрчлөлтөд мэдрэмжтэй байх ёстой. Дээд шүүхийн олон хэрэг зөвхөн хууль зүйн техникийн асуудал бус, хууль ба нийгэмд болж байгаа үйл явдлын нарийн шүтэлцээ, харилцан үйлчлэлийг хамардаг. Ялангуяа үндсэн хуулийн маргаанд ийм байдаг. Шүүгч эдгээр нийгмийн үйл явдал, нөхцөлийг хүлээн авч, зөв дүгнэлт хийж, хэргийг шударга шийдвэрлэх чадвартай байх ёстой.

<sup>30</sup> Ёс суртахууныг эрхэмлэх зориг (Moral courage) гэх шалгуур нь шүүхийн бие даасан байдалтай холбоотой шалгуур бөгөөд шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал нь Канадын Үндсэн хуульд үгчлэн заагаагүй ч “Үндсэн хуулийн бичигдээгүй зарчим” болдог. Шүүгч аливаа хэрэг, маргаан шийдвэрлэхдээ гадны аливаа нөлөөллөөс ангид байх чадвартай байх ёстой. Ялангуяа Дээд шүүхийн шүүгч Засгийн газар, олон нийт, тэр байтугай хамтран ажиллагсдынхаа санаа бодлоос ялгаатай шийдвэр гаргах үе тохиолддог тул ёс суртахууныг эрхэмлэх зориг шаардана.

<sup>31</sup> <https://www.fja-cmf.gc.ca/scc-csc/2023/nominee-candidate-eng.html>

<sup>32</sup> Манай улсын тухайд нэгэн адил нэр дэвшигчдээс мэргэжлийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга авдаг.

<sup>33</sup> Хэргийн үйл баримтын талаарх илэрхийлэл, хууль зүйн дүгнэлт

<sup>34</sup> Тухайлбал, нэр дэвшигч Мэри Мору өөрийнхөө бичсэн нэг шүүхийн шийдвэрийг сонгохдоо дараах байдлаар тоймлосон байна:

- Дараах сэдвийн хүрээнд шүүх эрх мэдэл, Канадын эрх зүйн тогтолцоотой холбоотой төрөл бүрийн асуудлын талаарх санал бодлоо илэрхийлсэн эсээ бичнэ. Сэдэв тус бүрийн хүрээнд 750-1000 үгэнд багтаана:
  - о Канадад хууль ёс, шударга ёс тогтооход таны оруулсан хувь нэмэр;
  - о Канадчуудын олон талт, ялгаатай байдал, тэдний онцлог үзэл хандлагын талаарх таны ойлголт, туршлага;
  - о Үндсэн хуульт ардчилсан нийгэм дэх шүүгчийн гүйцэтгэвэл зохих чиг үүрэг;
  - о Канадын Дээд шүүхийн шийдвэрийн үр нөлөө, цар хүрээний талаар;
  - о Канадын Дээд шүүхийн эрх зүйн тогтолцооны хэмжээнд чухал ач холбогдолтой хууль зүйн асуудлын хүрээнд удирдамжаар хангах хэрэгцээ шаардлага болон хэргийн оролцогчид шударга бус үр дагавар бий болгохуйц хэргийн тодорхой үйл баримтын хоорондын уялдаа холбоог хангах чиг үүргийн талаар.

2023 оны сонгон шалгаруулалтын хүрээнд Канадын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн өргөдлийг 2023 оны 6 дугаар сарын 20-ноос мөн оны 7 дугаар сарын 21 хүртэлх хугацаанд хүлээн авсан ба Зөвлөх зөвлөлд нийт 13 хүн (6 эмэгтэй, 7 эрэгтэй, өөр хүйсийн хүн байгаагүй) өргөдөл ирүүлсэн байна.<sup>35</sup> Зөвлөх зөвлөл нь өргөдөл, эсээ, нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, ярилцлага хийх зэрэг аргаар нэр дэвшигчийн ёс зүй, хууль зүйн болон хос хэлний<sup>36</sup> мэдлэг,

<sup>35</sup> “KS-ийн эсрэг Willox-ын хэрэг, 2016 ABQB 483, батлагдсан 2018 ABCA 271, Канадын Дээд шүүхэд гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхисон, 38346 (2019 оны 4 дүгээр сарын 18).

Тус маргаан нь хүүхдийн асран хамгаалагчаас хүүхдийн эмч, зөвлөх эх барих эмчид холбогдуулж гаргасан эмчийн мэргэжлийн үйл ажиллагааны доголдлын улмаас хүүхэд дутуу төрсөнтэй холбоотой маргаан юм. Дутуу төрсөн хүүхдэд хожуу илэрсэн мэдрэлийн үйл ажиллагааны эмгэгийн улмаас хүүхэд хөгжлийн хоцрогдолд орж, аутизмтай, мөн нэг нүд нь хараагүй болсон. Нэхэмжлэгчийн зүгээс эмч нар эхэд жирэмсний хугацааг уртасгах болон ургийн гэжиг үүсэхээс урьдчилан сэргийлэх эмчилгээний боломжийн талаар зөвлөгөө өгөөгүй, эхийг эмчлэх үүргээ зөрчсөн гэж маргасан. Миний бие энэ маргааныг нэхэмжлэгч хүүхдийн эмчийн эс үйлдэл болон хүүхдэд учирсан гэмтэл хоёрын хоорондын шалтгаант холбоог тодорхойлж чадаагүй тул хүүхдийн эрүүл мэндийн асуудалд эмч хариуцлага хүлээхгүй гэж шийдвэрлэсэн. Ингэхдээ хүүхдийн асрамжид холбогдуулан улсаас тэтгэмж олгох эсэх нь баталгаатай биш байсан тул хамаарч болох гэмтлийн бусад ялгаатай төрлүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр ийнхүү хүүхдийн цаашдын асрамжид зориулж улсаас олгох тэтгэмжийг хасаж болохгүй гэж шийдвэрлэсэн болно.

Шинжлэх ухааны нотолгооны нарийн төвөгтэй байдал болон өөрийнхөө дүн шинжилгээ хийх ур чадварыг харуулах зорилгоор тус шийдвэрийг сонголоо” гэжээ.

<sup>35</sup> <https://www.fja-cmf.gc.ca/scc-csc/2023/report-rapport-eng.html>

<sup>36</sup> Англи, франц хэл

ур чадварыг үнэлэх ажиллагааг явуулж, 3-5 нэр дэвшигчийг Ерөнхий сайдад санал болгоно. Энэхүү сонгон шалгаруулалтын дагуу Мэри Мору шүүгч 2023 оны 11 дүгээр сарын 06-нд Канадын дээд шүүхийн шүүгчээр томилогдсон байна.

Нэгтгэвэл, Канадын дээд шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтын хүрээнд нэр дэвшигчээс нэг удаагийн бичгийн шалгалт авдаггүй байх бөгөөд Дээд шүүхэд нэр дэвших өргөдөл гаргагч нь шүүгч бол шүүхийн шийдвэр, өмгөөлөгч бол хууль зүйн баримт бичиг (factum), нийтлэл зэргээс өөрийнх нь мэдлэг, ур чадварыг хамгийн сайн илэрхийлж чадах тавыг сонгож, тэдгээрийн шийдвэрлэлт, яагаад үүнийг сонгосон үндэслэл, шалтгааны талаар төдийгүй эсээ бичиж өгнө. Эдгээр нь нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг үнэлэхэд чухал нөлөөтэй бөгөөд нэр дэвшигчтэй хийх ярилцлагаар өргөдөлдөө хавсаргасан тайлбар, эсээний агуулгыг гүнзгийрүүлэн авч үздэг байна.

## 5.2. Шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг шалгах арга хэлбэр

*Хүснэгт 9. Мэргэшил, ёс зүй, төлөвийг үнэлэх шалгуур, эх сурвалж*

Нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, төлөвийг үнэлэх шалгуур		Үнэлгээний эх сурвалж
<b>Нэр дэвшигчийн мэргэшлийг үнэлэх шалгуур:</b>		1. Нэр дэвшигчтэй хийсэн ярилцлага а. Илтгэгч гишүүний ярилцлага б. Ерөнхий зөвлөлийн ярилцлага 2. Нэр дэвшигчийн баримт бичиг 3. Нэр дэвшигчийн мэргэшил, чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлт 4. Сонирхсон этгээдээс хүлээн авсан санал
1	шүүн таслах ажлын, эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааны туршлага, чанар – 2 хүртэл оноо	
2	мэргэжил, мэдлэг боловсролоо дээшлүүлж, хөгжүүлж байгаа байдал – 2 хүртэл оноо	
3	дүн шинжилгээ хийх, үндэслэл гаргах чадвар – 2 хүртэл оноо	
4	оновчтой илэрхийлэх чадвар – 2 хүртэл оноо	
5	харилцааны ур чадвар – 2 хүртэл оноо	
<b>Нэр дэвшигчийн ёс зүй, зан төлөвийг үнэлэх шалгуур:</b>		
1	хараат бус, бие даасан байдал – 3 хүртэл оноо	
2	зарчимч, үнэнч, шударга байдал – 3 хүртэл оноо	
3	төвийг сахих чанар – 2 хүртэл оноо	
4	зохистой байдал – 2 хүртэл оноо	

Нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, төлөвийг үнэлэх шалгуур		Үнэлгээний эх сурвалж
5	хүмүүст тэгш хандах, хэвшмэл явцуу үзлээс ангид байдал – 2 хүртэл оноо	5. Илтгэгч гишүүний тайлан 6. Бусад
6	хичээл зүтгэл – 2 хүртэл оноо	
7	шийдэмгий чанар – 2 хүртэл оноо	
8	ажил хэргийн болон мэргэжлийн нэр хүнд – 2 хүртэл оноо	
9	ажил хэргийн болон хувийн зохион байгуулалт – 2 хүртэл оноо	

Монгол Улсын шүүгчийн сонгон шалгаруулалт нь голчлон нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадварыг шалгахад чиглэж байсан бол 2013 оноос хойш<sup>37</sup> шүүгчид нэр дэвшигчийн ёс зүй, зан төлөвийг шалгах арга, хэлбэрийг нэвтрүүлэн ашиглаж байна. Монгол Улсын шүүхийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд болсон нийт 9 удаагийн сонгон шалгаруулалтын тоон мэдээнээс үзэхэд хууль зүйн мэддлэг, чадварын шалгалтад тэнцсэн 185 нэр дэвшигчээс 6 нэр дэвшигч мэргэшил, ёс, зан төлөвийн шалгалтад тэнцээгүй байх бөгөөд энэ нь 3.2% болох юм.


<sup>37</sup> Бүр годруулбал, 2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, түүний дагуу баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 165 дугаар зарлигаар батлагдсан “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-аас хойш.

Хүснэгт 10. Мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад тэнцсэн байдал

	Зарласан сул орон тоо /нийт/	Нэрээ дэвшүүлсэн хуульч	Бүртгэгдсэн нэр дэвшигч	Бүртгэхээс татгалзсан нэр дэвшигч	Бүртгэлтэй холбоотой гаргасан гомдлын тоо	Гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн	Үнэлгээ болон зохион байгуулалттай холбогдуулан гаргасан гомдлын тоо	Тэнцсэн нэр дэвшигчийн тоо	
								Хууль зүйн мэдлэг чадварын шалгалт	Мэргэшил ёс зүй, зан төлөвийн шалгалт
Сонгон 1	21	195	149	46	9	1	2	12	12
Сонгон 2	35	183	126	57	19	3	-	20	20
Сонгон 3	34	175	125	50	10	2	28	18	18
Сонгон 4	64	200	137	63	12	2	11	21	18
Сонгон 5	68	171	151	20	6	-	12	27	26
Сонгон 6	58	158	136	22	7	-	4	20	20
Сонгон 7	35	99	73	26	6	-	5	6	6
Сонгон 8	11	68	57	11	2	-	3	3	3
Сонгон 9	117	321	272	55	15	3	14	58	56
Нийт	443	1570	1226	350	86	11	79	185	179


Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх

**Асуумж:** Шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг шалгаж буй арга хэлбэр, шалгуур нь тохиромжтой эсэх буюу хамгийн сайн шүүгчийг шилж олох зорилгод нийцэж байгаа эсэх?



Асуулгад оролцсон 34 шүүгчийн хариултын үр дүнгээс үзэхэд шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг шалгаж буй арга хэлбэрийг “сайн” гэж үзсэн оролцогч харьцангуй бага, олонх нь “муу”, “дунд” гэж үзсэн байна.

**Асуумж.** Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүд нь шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг үнэлэхдээ шударга бөгөөд бодитой ханддаг (1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлнэ үү. 1 нь маш муу, 5 нь маш сайн гэсэн үр дүнг илтгэнэ) эсэхийг асуулгад оролцогчид дараах байдлаар үнэлсэн байна.



Ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-д зааснаар нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтын үе шат, үнэлгээ хийх эх сурвалжийг дараах байдлаар заасан байна.

*Хүснэгт 11. Нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүйн, зан төлөвийг үнэлэх үе шат*

1	2	3	4	5
Нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнд тохиолдлын журмаар хуваарилах	Илтгэгч гишүүн тайлан бичих	Илтгэгч гишүүн нэр дэвшигчийн мэргэшил, чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлт гаргах	Ерөнхий зөвлөл нэр дэвшигчтэй ярилцлага хийх	Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг үнэлж, үнэлгээ өгөх
<ol style="list-style-type: none"> <li>нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичгийг судлах;</li> <li>Нэр дэвшигчийн талаар сонирхсон этгээдээс ирүүлсэн саналд дүн шинжилгээ хийх;</li> <li>мэдээлэл авах зорилгоор 10-аас доошгүй хүнтэй ярилцлага хийх;</li> <li>нэр дэвшигчтэй ярилцлага хийх.</li> </ol>				

Өөрөөр хэлбэл, нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг 1) нэр дэвшигчтэй хийсэн ярилцлага; 2) нэр дэвшигчийн баримт бичиг; 3) нэр дэвшигчийн мэргэшил, чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлт; 4) сонирхсон этгээдээс хүлээн авсан санал; илтгэгч гишүүний тайлан; 5) шаардлагатай бусад гэсэн эх сурвалжид үндэслэн үнэлэхээр зохицуулсан байна.

#### *А. Америкийн Нэгдсэн Улсын туршлага*

Америкийн барын холбооны “Холбооны шүүхийн асуудал хариуцсан байнгын хороо” шүүгчид нэр дэвшигчийн мэргэжлийн байдлыг үнэлэх чиг үүрэгтэй бөгөөд бусад улсын холбогдох эрх бүхий байгууллагуудаас ялгаатай нь нэр дэвшигчийг санал болгодоггүй, гагцхүү мэргэжлийн ур чадвар, ёс зүй, зан төлөвийг үнэлдэг, тийнхүү үнэлсэн үр дүнгээ Сенатын шүүхийн хороонд хүргүүлдгээрээ онцлогтой.<sup>38</sup> Иймд АНУ-ын шүүхийн томилгоог хариуцдаг бусад эрх бүхий байгууллагыг нуршихгүйгээр энд тус хороо ёс зүй, зан төлөвийн шалгуурыг үнэлэх, ярилцлага хийх талаарх хэсгийг тоймлон авч үзье. Хороо нь тойргийн шүүх тус бүрээс нэг, 9 дүгээр тойргийн шүүхээс хоёр, нэг дарга гэсэн нийт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй ба Барын холбооны Ерөнхийлөгч 3 жилээр томилдог, мэргэжлийн ур чадвар, ёс зүйн өндөртэй гишүүдээс бүрддэг. Ингэхдээ шүүгчид нэр дэвшигчийг дараах үндсэн гурван шалгуурын хүрээнд үнэлнэ:<sup>39</sup>

- Ёс зүй: нэр хүнд, үнэнч шударга байдал, хичээл зүтгэл;
- Мэргэжлийн ур чадвар: Оюуны чадамж, шүүн тунгаах чадвар, бичгийн ур чадвар, хууль зүйн мэдлэг, туршлага;
- Шүүгчийн зан төлөв: Энэрэх сэтгэл, тэвчээр, харилцааны соёл, нээлттэй хандлага, шийдэмгий, шударга байдал.

Дээрх шалгуурын хүрээнд нэр дэвшигч тус бүрд шалгагч/үнэлгээч томилох бөгөөд үнэлэх этгээд нь тухайн нэр дэвшигчийн харьяаллын шүүхээс байна. Үнэлгээ нь дараах үе шатаар явагдана:<sup>40</sup>

<sup>38</sup> ABA, Standing Committee on the Federal Judiciary, What It Is and How It Works (July 2025), <[https://www.americanbar.org/content/dam/aba/administrative/federal\\_judiciary/fjc-backgrounder-2025.pdf](https://www.americanbar.org/content/dam/aba/administrative/federal_judiciary/fjc-backgrounder-2025.pdf)> (Сүүлд үзсэн: 2025.10.01).

<sup>39</sup> *ibid* 3.

<sup>40</sup> *ibid* 4-5.

1. Нэр дэвшигчийн өргөдөл, бичгийн ур чадвар, сахилгын зөрчлийн бүртгэлийг хянан шалгана.
2. Нэр дэвшигчийн талаар шүүгч, хуульч, хууль зүйн сургуулийн багш, харьяалагдах бусад бүлгэмийн удирдагч болон хамтран ажиллагсад зэрэг 40-өөс доошгүй хүнтэй нууц ярилцлага хийнэ. (Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшиж байгаа тохиолдолд ярилцах хүний тоо үүнээс олон байна)
3. Дээрх үе шат дуусмагц нэр дэвшигчтэй ганцаарчилсан ярилцлага хийнэ.

Ярилцлагын агуулга дээр дурдсан гурван шалгуурын хүрээнд өрнөх бөгөөд аливаа шүүмжлэл, сөрөг сэтгэгдэлд хариу тайлбар өгөх, сахилгын зөрчлийн түүх, эрүүл мэндийн асуудлаа тайлбарлах бүрэн боломжоор нэр дэвшигчийг хангана.

Нэр дэвшигчтэй ярилцсаны дараа шалгагч/үнэлгээч албан болон албан бус гэсэн хоёр тайлан бэлтгэх бөгөөд дараах үнэлгээний аль нэгийг урьдчилан санал болгож өгсөн байна.<sup>41</sup>

- Шалгуур сайн хангасан: мэргэжлийн ур чадвар, ёс зүй, зан төлөв сайтай;
- Шалгуур хангасан: өндөр шалгуурт нийцсэн, шүүгчийн чиг үүрэг гүйцэтгэх чадвартай;
- Шалгуур хангаагүй: нэг буюу хэд хэдэн асуудлаар шалгуур хангаагүй.

Шалгагч/үнэлгээчийн дээрх үнэлгээг бүх гишүүний саналаар батлах бөгөөд олонхын санал авч байж албан ёсны болно.

Дээрх байдлаар нэр дэвшигчийн талаар хүмүүстэй ярилцлага хийх шалгуурыг хэтэрхий уламжлалт бөгөөд шүүхийн салбарт ажилласан нэр дэвшигчдэд илүү давуу талтай, өөр бусад салбарт ажилласан хуульчдыг (жишээ нь хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч, иргэний нийгмийн байгууллагын хуульч зэрэг) бүрэн илэрхийлж чадахааргүй гэж судлаачид шүүмжилдэг<sup>42</sup> байна. Тухайлбал, шүүгчид

<sup>41</sup> ibid 6.

<sup>42</sup> Maya Sen, "How Judicial Qualification Ratings May Disadvantage Minority and Female Candidates", 2 (1) Journal of Law and Courts 2014: 33-65 <<https://www.jstor.org/stable/10.1086/674579>>; Richard L. Vining

нэр дэвшигчдийн мэргэжлийн туршлагад дүн шинжилгээ хийхэд шүүгчийн туслахаар, ялангуяа давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслахаар ажилласан нэр дэвшигч “шалгуур сайн хангасан” үнэлгээ авах боломж 58% буюу шүүхэд ажилласан туршлагагүй бусад нэр дэвшигчээс 17%-аар өндөр байжээ.<sup>43</sup>

### *Б. Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын туршлага*

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс (цаашид “Өмнөд Африк” гэх)-ын 1994 оноос өмнөх шүүхийн томилгоо бие даасан, хараат бус байдлыг хангах механизмд нийцдэггүй байсан буюу шүүгч томилох үйл явц Их Британийн колоничлолд байсан бусад улстай төстэй байдлаар явагддаг байсан.<sup>44</sup> Тодруулбал, шүүгчдийг Хууль зүйн сайд томилдог, шүүгч нь эрх зүйн байдлын хувьд төрийн албан хаагчид тооцогддог байсан. Харин 1994 оноос эрс шинэтгэл хийж, Шүүхийн үйлчилгээний хороо хэмээх шүүхийн зөвлөлийн чиг үүрэгтэй байгууллага байгуулж, шүүгчийг Шүүхийн үйлчилгээний хорооны санал болгосноор Ерөнхийлөгч томилдог<sup>45</sup> болжээ.

Шүүхийн үйлчилгээний хороо нь 23 гишүүний бүрэлдэхүүнтэй ба үүнд шүүхийн төлөөллөөс гадна Ерөнхийлөгчийн томилсон 4 хүн, Парламентын 6 гишүүн (гурваас доошгүй нь парламент дахь сөрөг хүчний гишүүн байх), хууль зүйн сайд зэрэг улс төрийн институцийн төлөөлөл байна. Ингэснээр Өмнөд Африкийн загвар нь шүүх өөрөө өөрийгөө томилдог тогтолцоонд тулгарч болзошгүй эрсдэлээс зайлсхийдэг боловч нөгөө талаас Канад, Намиби, Англи, Уэльс, Австрали зэрэг төстэй зохицуулалттай улсуудтай харьцуулахад шүүхийн томилгоо дахь гүйцэтгэх эрх мэдлийн эрх хэмжээг хязгаарласан.<sup>46</sup> Гэсэн хэдий ч шүүхийн томилгоог бүх холбогдох талыг оролцуулсан олон талт, хамтын шийдвэр болох боломжийг бий

---

Jr et al, “Bias and the Bar: Evaluating the ABA Ratings of Federal Judicial Nominees” April 2009 <[https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract\\_id=1368891](https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=1368891)>; Austin R Nelson, “Evaluating the Evaluator: Has the ABA Rated President Trump’s Judicial Nominees Fairly?”, 99 Texas Law Review 2020: 194-212 <<https://texaslawreview.org/wp-content/uploads/2020/11/Nelson.Printer.pdf>> зэрэг өгүүллээс дэлгэрүүлэн үзнэ үү.

<sup>43</sup> Richard L Vining Jr et al, (n 40) 17.

<sup>44</sup> Francois Du Bois, “Judicial Selection in Post-Apartheid South Africa” in Kate Malleson and Peter H Russell (eds), *Appointing Judges in an Ages of Judicial Power* (University of Toronto Press: Toronto, 2006) 283.

<sup>45</sup> Өмнөд Африкийн Үндсэн хуулийн 174 дүгээр зүйлийн (3), (7).

<sup>46</sup> Francois Du Bois (n 42) 285.

болгосноор шүүхийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын ойлголт бүрдэж, улс төр, хууль зүйн салбарынхны дундах маргааныг бууруулсан байх талтай гэж үздэг.<sup>47</sup>

Өмнөд Африкийн Шүүхийн үйлчилгээний хорооноос 2022 онд шинэчлэн баталж, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа “Шүүгчийн сонгон шалгаруулалтад нэр дэвшигчийг үнэлэх шалгуур, удирдамж”<sup>48</sup>-д нэр дэвшигчийн ур чадвар, ёс зүй, зан төлөвийг үнэлэхдээ “цогц хандлага” баримталж дараах зүйлсийг харгалзан үзэхээр заажээ:<sup>49</sup>

- 13 Нэр дэвшигч шүүгчээр томилогдоход тохиромжтой эсэхийг цогцоор үнэлэх зорилгоор ёс зүй, мэдлэг, судалгааны ур чадвар, туршлага, нэр төрөө эрхэмлэх, даруу байдал, шүүн тунгаах чадвар, онч мэргэн, хараат бус байдал, зан төлөв, зориг, шүүхийн шинжилгээний ур чадвар, илтгэх чадвар, эрч хүч, хөдөлмөрч хичээнгүй байдал зэрэг олон хүчин зүйлийг өргөн, нэгтгэсэн байдлаар авч үзнэ. Зан төлөвийг үнэлэхдээ нэр дэвшигчийн шударга, үнэнч, найдвартай эсэх, хэлсэн үгэндээ хүрдэг эсэх зэргийг анхаарна.
- 15 Шүүгч ардчиллын суурь үнэт зүйл, хууль дээдлэх ёс, хүний үндсэн эрхийн хамгаалалд ... нийцүүлэн Үндсэн хуулийг тайлбарлан хэрэглэх ёстой. Шүүгч Үндсэн хуульд заасан зарчмуудыг ялгаж ойлгодог, тодорхой илэрхийлдэг байна. Жишээлбэл, шүүгч орлого багатай иргэдийн шүүхэд хандах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн эрхийг хэрэгжүүлэх ач холбогдлыг ухамсарладаг байх ёстой.
- 16 Нэр дэвшигч өмнө нь гарсан шүүхийн бусад шийдвэрийг хэрэглэх, ялгах чадвартай, эрх чөлөө, тэгш байдалд суурилсан нээлттэй, ардчилсан нийгмийн ёс суртахууны итгэл үнэмшлийг илэрхийлэх чадвартай байна. Шүүгч аливаа үндэслэлтэй тайлбарыг харгалзан үзээгүй бол тийнхүү татгалзсан шалтгаанаа үндэслэлтэйгээр товч тайлбарлах чадвартай байна. Гаргасан шийдвэрээ холбогдох бүх хүнд товч, ойлгомжтой тайлбарлах чадвартай байна.
- 17 Дээрх бүгд шүүх шинжилгээний болон оюуны ур чадвар, шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практик ойлголт, хууль зүйн ерөнхий болон тусгай мэдлэг, эрх зүйн процессын мөн чанарыг сахин хамгаалахад холбогдох журам, ёс зүйн хариуцлагыг мэддэг байхыг шаардана.

Мөн дээрх удирдамжийн тайлбарт нэр дэвшигчээс ярилцлага авахад баримтлах зүйлийг дараах байдлаар зааснаараа онцлог байна:<sup>50</sup>

<sup>47</sup> *ibid.*

<sup>48</sup> Judicial Service Commission, Summary and Explanation of the Criteria and Guidelines Used by the Judicial Service Commission when Considering Candidates for Judicial Appointment (4 April 2022), <[https://www.concourt.org.za/images/Criteria\\_and\\_Guidelines\\_Used\\_By\\_The\\_JSC\\_For\\_Judicial\\_Appointment.pdf](https://www.concourt.org.za/images/Criteria_and_Guidelines_Used_By_The_JSC_For_Judicial_Appointment.pdf)> (Сүүлд үзсэн: 2025.09.29).

<sup>49</sup> *Ibid* 4-5.

<sup>50</sup> *ibid* 9-10.

- 33 Хорооны гишүүн нэр дэвшигчээс шалгуурт хамааралтай асуулт асууна. Шүүхийн үйлчилгээний хорооны дарга энэ удирдамжийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй. ...
- 34 Нэр дэвшигчээс тухайн асуудал шүүхээр шийдвэрлэх хэрэг байсан бол яаж шийдвэрлэх байсан талаар урьдчилан амлалт өгөх эсхүл үүрэг болгосон байдлаар, хариулах боломжгүй асуулт асууж болохгүй. Шүүгч талуудын байр суурийг сонсохоос өмнө шийдвэр гаргах боломжгүй тул ийм төрлийн асуулт даалгасан асуудлыг хараат бусаар, нээлттэй хандлагаар шийдвэрлэх шүүгчийн үндсэн чиг үүрэгтэй үл нийцнэ. Нэр дэвшигч аливаа хэрэг маргааныг төвийг сахиж шийдвэрлэх учир хэргийн нарийн ширийнийг орхигдуулж болзошгүй сэжүүр, урьдчилсан таамаг өгөхийг хориглоно.
- 35 Шүүгчийн сонгон шалгаруулалтын зорилго шүүхэд хамгийн сайн шаардлага хангасан нэр дэвшигчийг олж илрүүлэх (discover), хамгийн өндөр зэрэглэлийн шүүгчийг томилоход оршино. Иймд шалгуур хангаагүй дээр биш, шалгуур хангасан дээр төвлөрөх нь эрэл хайгуулын эн тэргүүний зорилт болно.
- 36 Энэ нь Шүүхийн үйлчилгээний зөвлөл шүүгчээр ажиллах боломжийг үгүйсгэх шинжтэй ноцтой мэдээллийг үл тоомсорлож болно гэсэн үг биш юм. Ийм төрлийн мэдээлэл нэр дэвшигчийн нэр хүнд, эрхэм чанарт нөлөөлөх, хувь хүний нууцад халдах, шүүхийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул дараах зүйлийг удирдлага болгоно:
- 36.1 Мэдээлэл үнэн тохиолдолд нэр дэвшигчийг “зохих шалгуур хангасан” гэдэгт хамааруулахгүй байх хэмжээний шинж чанартай байна;
- 36.2 Мэдээллийг үндэслэх хангалттай нотлох баримт байхгүй тохиолдолд нэр дэвшигчтэй хийх ярилцлагын үеэр тус асуудлыг хөндөхгүй;
- 36.3 Нэр дэвшигчид аливаа асуулт тавихаас өмнө тухайн мэдээллийг авч үзэх, хариу тайлбар өгөх хангалттай боломж олгоно;
- 36.4 Шүүхийн үйлчилгээний зөвлөл Өргөдлийн хорооны саналыг авна.

Жич: Энд дурдсан Өргөдлийн хороо (англ. The Objection Committee) нь Өмнөд Африкийн Шүүхийн үйлчилгээний зөвлөлийн дотоод нэгж бөгөөд шүүхийн сонгон шалгаруулалтад оролцож байгаа нэр дэвшигчтэй холбоотой өргөдөл, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх үүрэгтэй. Нэр дэвшигчтэй холбоотой тодорхой өргөдөл, мэдээллийг харгалзан үзэх шаардлагатай эсэх, нэр дэвшигчээс ямар нөхцөлд яаж асуух талаар Шүүхийн үйлчилгээний хороонд санал, зөвлөмж өгнө.

Дээрхээс үзвэл шүүгчид нэр дэвшигчтэй хийх ярилцлага, үнэлэх арга хөндлөнгийн, нүүрэлдүүлэх аргаар биш (cross-examination), цогц үнэлгээнд суурилагаар байна. Ингэхдээ ярилцлагын үр дүнд нэр дэвшигчийн хувийн үзэл баримтлал, улс төрийн үзэл бодол гэхээс илүү шүүгчээр ажиллахад шаардах зан төлөв, хандлага, хараат бус байдал, ёс зүйн хандлага тодорхой болох ёстой нь удирдамжийн агуулгаас харагдаж байх боловч практикт эсрэгээрээ байх тохиолдол байдгийг мөн дээр дурдсанаас харж болох юм. Гэсэн хэдий ч удирдамж нь зарчмын хувьд авууштай заалт ихтэй, ойлгомжтой зохицуулсан байгааг дурдах нь зүйтэй.

Мөн Шүүхийн үйлчилгээний хороо нь шүүгчийн сул орон тоог зарлаж, нэр дэвшүүлэх эцсийн хугацааг зааж өгнө. Нэр дэвшүүлэх ажиллагаа дуусмагц Шүүхийн үйлчилгээний хорооны дэд хороо болох 9 гишүүнтэй “Шалгалтын хороо” нь нээлттэй ярилцлага (public interview)-д оролцох нэр дэвшигчдийн жагсаалт (short list) гаргана.<sup>51</sup>

Шалгалтын хорооноос жагсаалт гаргасны дараа Шүүхийн үйлчилгээний хороо хууль зүйн байгууллагууд болон олон нийтийг нэр дэвшигчдийн талаар санал хүсэлтээ ирүүлэхийг урина. Уг саналд байгууллага, олон нийт нэр дэвшигч шүүгч болоход тохирох эсэх талаар холбогдох мэдээлэл өгөх боломжтой. Шүүхийн үйлчилгээний хороо нь нэргүй санал хүлээн авахгүй бөгөөд энэ үйл явцаар дамжуулан ёс зүйн зөрчлийн талаарх гомдол гаргахыг зөвшөөрдөггүй. Хэрэв нэр дэвшигчийн эсрэг ямар нэгэн сөрөг санал байвал Шүүхийн үйлчилгээний хороо тэдгээрийг нэр дэвшигчдэд илгээж, бичгээр тайлбар өгөхийг хүснэ.<sup>52</sup> Үүний дараа Шүүхийн үйлчилгээний хороо ихэвчлэн Гаутенг хотод байрлах талбайд нэр дэвшигчдэд зориулсан нээлттэй ярилцлага зохион байгуулдаг.<sup>53</sup> Ингэхдээ ярилцлагын хувьд тогтсон асуулт байхгүй бөгөөд хамгийн түгээмэл асуулт нэр дэвшигчийн шүүхийн шинэтгэлийн талаарх мэдлэг, хандлагад чиглэдэг.

Түүнчлэн, Шүүхийн үйлчилгээний хорооноос шүүгчийн сонгон шалгаруулалт явуулахдаа зөвхөн хууль зүйн мэдлэг, туршлагаар хязгаарлахгүй, хараат бус байдал, уян хатан, нээлттэй сэтгэлгээ, оюуны чадамж, тэгш байдлын үнэлэмж, хүлээн авах чадвар, хөдөлмөрч хичээнгүй байдал, зориг, ёс зүйтэй байх зэрэг эерэг зан төлөвөөс гадна бялдууч, үнэнч бус зан, ашиг хонжоо хайх, зохисгүй авирлах зэрэг сөрөг шинж чанарыг үнэлэхийг зорих болжээ.<sup>54</sup>

Шүүхийн үйлчилгээний хорооны нэр дэвшигчтэй хийх ярилцлага олон нийтэд нээлттэй буюу ярилцлагыг олон нийт үзэх боломжтой, эсхүл ярилцлагыг YouTube дээр шууд дамжуулах, радио, телевизээр нэвтрүүлдэг.<sup>55</sup> Ийнхүү нэр дэвшигчтэй хийх ярилцлага нээлттэй

<sup>51</sup> <https://www.judgesmatter.co.za/the-jsc/how-to-become-a-judge/>

<sup>52</sup> *ibid.*

<sup>53</sup> *ibid.*

<sup>54</sup> Francois Du Bois (n 42) 293-4.

<sup>55</sup> Жишээ нь дараах холбоосоор орж, тодорхой нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагын шууд бичлэгийг үзэх боломжтой: <https://www.youtube.com/watch?v=ICCnEGMheKY>

явагддаг болохоос өмнө ёс зүй, зан төлөвийн шалгуурыг хэрхэн үнэлэх нь тодорхой бус, хаалттай хаалганы цаана юу болж байгааг мэдэх аргагүй байсан тул ярилцлагын үйл явцыг нээлттэй болгосон байна. Нэр дэвшигчийн хувьд хамгийн хэцүү хэсэг энэ үе шат байж болох ч нэр дэвшигч шүүгчийн албан тушаалд тохирох эсэхийг үнэлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.<sup>56</sup> Хэдий зарим нэр дэвшигчийн ярилцлага “санаа зовмоор, ичмээр” болсон гэх боловч ярилцлагын зарим холбогдох тэмдэглэлийг нээлттэй нийтлэх нь шүүхийн нийгмийн хариуцлагын мэдрэмжийг нэмэгдүүлэхэд нэмэртэй байгаа нь бодит жишээнээс ажиглагджээ. Тухайлбал, “Чөлөөт өрлөг (масон)” (англ. Freemasons) хэмээх шашны нийгэмлэгийн гишүүнээр удаан явсан нэр дэвшигч чухам үүнээсээ болоод удаа дараа сонгон шалгаруулалтад тэнцээгүй бөгөөд улмаар тус бүлгэмээсээ гарч, үндэслэлээ “тийм шашны бүлгэмийн гишүүн байх нь шүүгчийн албан тушаалтай зөрчилдөнө гэсэн олон нийтийн хүчтэй үзэл байгаа тул” гэж дурдсан байна. Мөн согтууруулах ундааны хамаарлын асуудлаас болоод тэнцээгүй нэр дэвшигчид дахин нэр дэвшихдээ өмнөх ярилцлагаас хойш гарсан ахиц дэвшлээ тайлагнадаг тохиолдол ч бий болж байна.<sup>57</sup>

Ярилцлагын дараа Шүүхийн үйлчилгээний хорооны гишүүд зөвлөлдөж, ярилцлагад хамрагдсан бүх нэр дэвшигчид, шүүхийн хэрэгцээ, аль нэр дэвшигч томилогдоход тохиромжтой талаар хэлэлцэж, нууц санал хураалтаар санал болгох нэр дэвшигчийг тодруулна.

Дүгнэвэл, шүүгчид нэр дэвшигчийн ёс зүй, зан төлөвийг үнэлэх нь субъектив (үнэлэгчийн хувийн үнэлэмжид суурилсан) шинжтэй байж болох талтай ч шүүхийн бие даасан байдал, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хангахад зайлшгүй шаардлагатай шалгуур юм. Ёс зүй, зан төлөвийн хувьд хангалтгүй хүн шүүгчээр томилогдсоноор шүүхийн нэр хүнд, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бууруулах эрсдэлтэй. Иймд шүүгчид нэр дэвшигчийн ёс зүй, зан төлөвийг үнэлэхдээ субъектив байдлыг аль болох бууруулахыг зөвлөдөг ч огт үнэлэхгүй байж болохгүй гэсэн үг. Харин субъектив хандлагыг бууруулахад дараах аргыг хэрэгжүүлэх боломжтой:

<sup>56</sup> <https://www.judgesmatter.co.za/the-jsc/how-to-become-a-judge/>

<sup>57</sup> Francois Du Bois (n 42) 296.


- *Нэр дэвшигчийн талаар аль болох олон хүнтэй ярилцлага хийх.* Дээд шатны шүүхэд нэр дэвшигчийн талаар илүү олон хүнтэй ярилцдаг АНУ-ын туршлагаас “хэдий чинээ олон хүнтэй ярилцана, төдий чинээ бодитой үнэлэх” боломж бий болж байгааг харж болох юм. Иймд шүүхийн шатлал хамаарахгүйгээр нэр дэвшигчийн талаар ярилцлага хийх хүний тоог 10-аас доошгүй гэж заасан Монгол Улсын одоогийн зохицуулалтыг өөрчилж, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн талаар ярилцлага хийх хүний тоог зохих хэмжээгээр нэмэгдүүлэх нь үнэлгээг бодитой, үр дүнтэй болгоход нэмэртэй юм.
- Нэр дэвшигчийн талаар ярилцлага хийхдээ *“стандартчилагдсан асуулга, үнэлгээний хуудас”* ашиглах нь субъектив хандлагыг бууруулах ач холбогдолтой. Жишээ нь “Энэ хүн ёс зүйн хувьд шүүгчийн албан тушаалд бүрэн тохирно гэж үзэж байна уу? гэсэн асуултад 1-5 оноо өгөх, хэрэв 1-2 оноо өгсөн бол ярилцлага хийж байгаа хүнээр заавал тайлбар бичүүлэх гэх мэт. 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хууль батлагдахаас өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 165 дугаар зарлигаар баталсан “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”<sup>58</sup>-ын 8.2-т “Ажлын алба нэр дэвшигчийн мэргэжлийн ёс зүйн талаар ... шаардлага хангасан 10 хүнээс 5-ыг тохиолдлын журмаар сонгож, асуулга авна. Асуулга нь зөвхөн тухайн нэр дэвшигчийн ёс зүйн холбогдолтой мэдээлэл байна” гэж заасны дагуу тухайн үед Мэргэшлийн хороо стандартчилагдсан асуулга боловсруулж, нэр дэвшигчийн талаар бусад хүмүүсээс асуулга авч байсан туршлагыг эргэн сэргээх нь зүйтэй.
- Нэр дэвшигчийг ёс зүй, зан төлөвийн үнэлгээнд оролцуулахгүй шууд хасах *ноцтой үндэслэл, шалтгааныг тодорхойлон журамлах.* Жишээ нь нэр дэвшигч өөрийнхөө талаар Ерөнхий зөвлөлд үнэн зөв мэдээлэл өгөөгүй, худал хэлсэн, бусдыг ялгаварлан гадуурхсан, доромжилсон, бэлгийн дарамт үзүүлж байсан зэрэг ноцтой үйлдлүүд нотлогдвол ёс зүй, зан төлөвийн шалгуурын үнэлгээнээс хасаж болох юм.
- Нэр дэвшигчтэй хийх ганцаарчилсан ярилцлагыг *олон нийтэд шууд дамжуулах, нээлттэй ярилцлагын хэлбэрээр хэрэгжүүлж байгаа* Өмнөд Африкийн туршлагыг нэвтрүүлэх боломжтой байна.

<sup>58</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=206089&showType=1>

## Зургаа. Ерөнхий зөвлөлөөс шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д “Ерөнхий зөвлөл энэ хуулийн 34.8-д заасан эрэмбийн дагуу нийтэд мэдээлснээс хойш ажлын таван өдрийн дотор зарлагдсан орон тоогоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг шүүгчээр томилуулах саналыг, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулснаар томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ” гэж заасан.

**Асуумж.** Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг шалгалтын үнэлгээний эрэмбийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид санал болгодог эрх зүйн зохицуулалтыг хэрхэн дүгнэж байна вэ? (1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлнэ үү. 1 нь маш муу, 5 нь маш сайн гэсэн үр дүнг илтгэнэ)



Асуулгад оролцсон шүүгчдийн 70 гаруй хувь нь Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг шалгалтын үнэлгээний эрэмбийн дагуу Ерөнхийлөгчид санал болгодог эрх зүйн зохицуулалтыг дэмжсэн байна.

Ерөнхий зөвлөлөөс Ерөнхийлөгчид санал болгох нэр дэвшигчийг хэрхэн тодруулахыг холбогдох хуулиудад дараах байдлаар зохицуулж иржээ:

**Шүүхийн тухай хууль (1993 он):** §42.1.Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвар, хувийн зан суртахуун, биеийн эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан нэр дэвшигч нэг бүрээр хэлэлцэж нууцаар санал хурааж олонхийн саналаар авсан нэр дэвшигчийг шүүгчээр томилуулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

**Шүүхийн тухай хууль (2002 он):** §31.1.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийн эрх зүйн мэдлэг, ажил хэргийн чадварын талаар гаргасан Мэргэшлийн хорооны дүгнэлт, хувийн зан суртахуун, биеийн эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан нэр дэвшигч нэг бүрээр хэлэлцэн нууцаар санал хурааж, олонхийн санал авсан нэр дэвшигчийг шүүгчээр томилуулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

**Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012 он):** §13.2.Шүүхийн ерөнхий зөвлөл нь энэ хуулийн 13.1-д заасан дүгнэлт, Шүүхийн мэргэшлийн хорооны үнэлгээ болон энэ хуулийн 12.2-д заасан Хуульчдын холбооны дүгнэлтийн хамт шүүгчийн албан тушаалд томилуулах нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг үнэлгээний дүнгээр эрэмбэлж гарган, илээр санал хураан олонхын санал авсан хүний нэрийг ажлын таван өдрийн дотор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

Киевийн зөвлөмжөөр “Шүүгчийн сонгон шалгаруулалт, үнэлгээ хийх бие даасан байгууллага байхад, шүүхийн зөвлөл нь сонгон шалгаруулалтын ажиллагаа нь процедурын дагуу явсан эсэхийг хянаж, сонгон шалгаруулах байгууллагаас санал болгосон нэр дэвшигчийг томилох эсхүл томилох эрх бүхий этгээдэд санал болгохыг хязгаарлах ёстой”<sup>59</sup> гэж, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны

<sup>59</sup> Kyiv Recommendations on Judicial Independence in Eastern Europe, South Caucasus and Central Asia (2010), Part I, p-1 <https://odhr.osce.org/odhr/KyivRec>

байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институци, хүний эрхийн газар (АИХЭГ)-аас тухайлан Ерөнхий зөвлөлийн нэр дэвшигчийг санал хурааж шийдвэрлэдэг арга нь мерит зарчим дээр суурилсан сонгон шалгаруулах системийг үгүйсгэсэн буруу нөлөө үзүүлж байна хэмээн шүүмжилж, энэхүү “санал хурааж сонгодог заалтыг хүчингүй болгох”-ыг зөвлөсөн<sup>60</sup> байдаг. Иймд 2021 онд Монгол Улсын шүүхийн тухай хуулийг шинэчлэн найруулж батлахдаа Ерөнхий зөвлөл шалгалтын үнэлгээний эрэмбийн дагуу шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгохоор заасан байна.

### 6.1. Нөөцөд байгаа нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгох

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Монгол Улсын шүүхийн тухай хуульд “32.8.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 32.2.1, 32.2.2-т зааснаас бусад тохиолдолд шүүгчийн сул орон тоо гарсан бол энэ хуулийн 34.8-д заасан нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтад тэнцсэн эрэмбийн дарааллыг баримтлан энэ хуулийн 35.1-д заасны дагуу өргөн мэдүүлнэ” гэсэн хэсэг шинээр нэмсэн. Энэ зохицуулалтын хүрээнд Ерөнхий зөвлөл шүүгч өндөр насны тэтгэвэр тогтоолгох, Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүх болон сэлгэн ажиллах боломжгүй давж заалдах шатны шүүхээс сонгогдсоноос бусад үндэслэл (жишээ нь: шүүгч өөрийн хүсэлтээр чөлөөгдсөн, эрүүл мэндийн шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, огцорсон гэх мэт<sup>61</sup>)-ээр шүүгчийн сул орон тоо гарсан тохиолдолд шинээр сонгон шалгаруулалт зарлахгүйгээр шалгалтын үнэлгээ нь хүчинтэй байгаа нэр дэвшигчдээс үнэлгээний эрэмбийн дагуу нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгох боломжтой болжээ.

Шүүгчийн сул орон тоо гарах бүрд сонгон шалгаруулалт зарлах тохиолдолд шалгалтад хангалттай тооны нэр дэвшигч тэнцэхгүй байх,

<sup>60</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас хийсэн “Монгол Улсын шүүхийн тухай, Шүүхийн захиргааны болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өгөх санал, дүгнэлт” (2020) 8 болон 62 дахь тал.

<sup>61</sup> Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгох үндэслэл.

сонгон шалгаруулалт тодорхой цаг хугацаа шаардагддаг зэргээс дутуу орон тоог хурдан хугацаанд нөхөж чадахгүй сөрөг асуудал (хэрэг хянан шийдвэрлэлтийн хугацаа удаашрах, шүүхийн ачаалал ихсэх гэх мэт) үүсдэг тул шалгалтын үнэлгээ нь хүчинтэй байгаа нэр дэвшигчдээс үнэлгээний эрэмбийн дагуу Ерөнхийлөгчид санал болгосноор сул орон тоог богино хугацаанд нөхөх сайн талтай байна. Гэвч нөөцөд бүртгэгдсэн нэр дэвшигчийн ёс зүй, зан төлөвийг дахин шалгах ажиллагаа хийхгүйгээр шууд Ерөнхийлөгчид өргөн мэдүүлдэг байх нь хэр оновчтой вэ гэдгийг анхаарах шаардлагатай болж байна. Өмнө нь ч шалгалтын үнэлгээ нь хүчинтэй байгаа нэр дэвшигчийн ёс зүй, зан төлөвийг дахин шалгадаггүй, өмнөх оноогоор нь тооцдог байсан. Гэтэл тухайн нэр дэвшигч шалгалтын үнэлгээ нь хүчинтэй байх (нөөцөд байх) хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан, шүүгч байхад тохирохгүй хууль бус, зохимжгүй үйлдэл гаргасан бол хэрхэх вэ? Энэ мэт асуудлыг тооцоолж шүүгчид нэр дэвшигчийн шалгалтын үнэлгээний хүчинтэй хугацаа, нөөцийн жагсаалт бүрдүүлэхдээ хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтын оноог хадгалан баримталж, харин шүүгчид нэр дэвших тохиолдол бүрд ёс зүй, зан төлөвийг дахин шалгадаг байх зохицуулалтыг хуульд тусгах нь оновчтой байж болох юм.

Нөгөө талаас сонгон шалгаруулалт зарлахгүй, нөөцөөс нэр дэвшүүлж байгаа гэдгээр аль ч шатны шүүхийн шүүгчээр ажиллах хуульд заасан болзол хангасан, шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй иргэний эрхийг хөндөж болохгүй тул тэнцвэрт байдлыг хангах сорилт үүсэж байна. Үүнийг шийдвэрлэх арга нь шүүгчийн сонгон шалгаруулалтыг жилд тогтмол зохион байгуулах байж болох юм. Өмнө нь хэрэгжиж байсан шүүгчийг сонгон шалгаруулах журмуудаар<sup>62</sup> шүүгчийн сонгон шалгаруулалтын суурь шалгалтыг жилд хоёроос доошгүй зохион байгуулж байсан туршлага бий.<sup>63</sup>

Мөн хэм хэмжээний түвшинд авч үзвэл Монгол Улсын шүүхийн тухай хуульд шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигчийн

<sup>62</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 103 дугаар зарлигийн хавсралт “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 19 дүгээр зарлигийн хавсралт “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”.

<sup>63</sup> Энэ нь яг ийм байх ёстой гэсэн утгаар бус шүүгчийн сонгон шалгаруулалтыг тогтмол хугацаанд зохион байгуулж байсан туршлага байсан гэдгийг сануулах утгаар бичив. П.Б

шалгалтын үнэлгээ хоёр жил хүчинтэй байна<sup>64</sup> гэж заасан ба энэ нь тухайн нэр дэвшигч хоёр жилийн хугацаанд дахин шалгалт өгөхгүйгээр өмнөх үнэлгээгээ тооцуулан шүүгчийн сул орон тоонд нэр дэвших эрхтэйг илтгэж байна. Өмнө үйлчилж байсан эрх зүйн зохицуулалт мөн ийм агуулгатай байсан. Харин шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигчийг нөөцөд бүртгэх, үнэлгээний эрэмбээр жагсаалт үүсгэх тодорхой заалт байхгүй байгааг анхаарч, цаашид эрх зүйн зохицуулалтыг нэг мөр, хоёрдмол утгагүй болгох шаардлагатай.

Түүнчлэн шүүгчид нэр дэвшигчийн шалгалтын үнэлгээ тодорхой хугацаанд хүчинтэй байх зохицуулалт 1993 оны Шүүхийн тухай хуулиас эхэлж тусгагдсан байдаг.<sup>65</sup> 2002 оны Шүүхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.8-д “Шүүгчид нэр дэвшигчийн эрх зүйн мэдлэг, ажил хэргийн чадварын талаар гаргасан дүгнэлт нэг жилийн хугацаанд хүчинтэй байна” гэж заасныг Улсын дээд шүүхийн 2003 оны “Шүүхийн тухай хуулийн зарим зүйл, заалтын тайлбарлах тухай” 01 дугаар тогтоолд “а/ шүүгчид нэр дэвшигчийн талаар “шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй” гэсэн дүгнэлт гарсан бол нэг жилийн хугацаанд тухайн этгээд дахин шүүгчийн сонгон шалгаруулалтад орох эрхгүй. б/“шүүгчийн албан тушаалд тэнцэнэ” гэсэн дүгнэлт гарсан хэдий ч шүүгчээр томилогдоогүй бол нэг жилийн хугацаанд дахин шалгалт өгч, дүгнэлт гаргуулахгүйгээр шүүгчийн сонгон шалгаруулалтад хамрагдах эрхтэй гэж тус тус ойлгоно.” гэж тайлбарласан байдаг.

Тэгвэл дээрх зохицуулалт 2012 оны Шүүхийн захиргааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7-д “Энэ хуулийн 23.6.1-д заасан үнэлгээ хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна” гэж, улмаар дагаж мөрдөж буй 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9-д “Энэ хуулийн 34.8-д заасан үнэлгээ хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна” гэж тусгагдсан байх ба уг зохицуулалт нь 2013 оноос хойш тухайн нэр дэвшигч шалгалтын үнэлгээ хүчинтэй байх хугацаанд уг үнэлгээгээ тооцуулан шүүгчийн сул орон тоонд шууд

<sup>64</sup> Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9 дэх хэсэг.

<sup>65</sup> Шүүхийн тухай хууль (1993 он). 391 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг. Шүүгчийн мэргэшлийн хороо нь нэр дэвшигчийн, түүнчлэн Ерөнхий зөвлөл буюу энэ хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2,3-т заасан шүүх бүрэлдэхүүн, албан тушаалтны хүсэлтээр шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварыг шалгаж дүгнэлт гаргана. Нэр дэвшигч болон шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын талаар гаргасан мэргэшлийн хорооны дүгнэлт 6 сарын хугацаанд хүчинтэй байна.

нэр дэвших, харин шалгалтад тэнцээгүй, түүнчлэн нэр дэвшигч өмнө нь авсан үнэлгээгээ ахиулах хүсэлтэй байгаа тул шалгалтад дархин оролцох эрхтэй гэсэн гэсэн агуулгаар хэрэгжиж байна. Энэ нь Улсын дээд шүүхийн 2003 оны “Шүүхийн тухай хуулийн зарим зүйл, заалтын тайлбарлах тухай” 01 дугаар тогтоолын тайлбартай зөрчилдөж байгаа юм.

## Долоо. Ерөнхийлөгч шүүгчийг ТОМИЛОХ НЬ

Олон улсын түвшинд Ерөнхийлөгч буюу Төрийн тэргүүн бүх шатны шүүхийн бус ихэвчлэн дээд шатны шүүхийн шүүгчийн томилгоонд оролцох нь түгээмэл байна. Франц, Итали, Португал, Испани тэргүүтэй эх газрын эрх зүйн тогтолцоотой Европын улсуудад шүүгч бэлтгэх чиг үүрэгтэй шүүгчийн сургууль, коллеж анхан шатны шүүгчийн сонгон шалгаруулалтын үндсэн суурь болж байхад шүүгч томилох, дэвшүүлэх, сахилгын зөрчил шийдвэрлэх, дээд шатны шүүхэд дэвшүүлэн ажиллуулах зэрэг асуудлыг Шүүхийн зөвлөл нь тус тус хариуцдаг. Харин Ерөнхийлөгч эдгээр үе шат явагдмагц гагцхүү “албажуулах” үүрэг гүйцэтгэдгээрээ нийтлэг юм.

ХБНГУ-ын хувьд харин шүүгчийн томилгоо холимог байдлаар явагддаг буюу мужийн түвшинд мужийн сайд, холбооны дээд шүүхийн түвшинд мөн сайд, шүүхийн сонгон шалгаруулах хороо шийдвэрлэснийг Холбооны улсын Ерөнхийлөгч гарын үсэг зурж, баталгаажуулна. Англи, Уэльс (Их Британи бүхэлдээ бус)-ийн хувьд шүүхийн академи, сургууль байхгүй тул бие даасан статус бүхий хороо бүх шатны шүүхийн шүүгчийг нээлттэй шалгаруулж сонгосныг Эзэн хаан/хатан ёсчлон томилдог.

Төрийн тэргүүний шүүгч томилох эрхийг цар хүрээгээр нь шийдвэрлэх шинжтэй, холимог шинжтэй, бэлгэдлийн шинжтэй гэж ангилж болох ба дараах хүснэгтэд шүүгчийг Ерөнхийлөгч/Төрийн тэргүүн томилдог 14 улсын мэдээллийг (Итали, Франц, Германыг давхардуулан сонгосон) харуулав:

## Хүснэгт 12. Хүснэгт 13-ын тайлбар, товч агуулга

Хэлбэр	Тайлбар
Шийдвэрлэх шинжтэй	Шүүгчийг томилоход Ерөнхийлөгч шийдвэрлэх (нэр дэвшүүлэх, олон нэр дэвшигчээс шалгуур хангасан эсэхийг хянасны үндсэн дээр) эрх хэмжээтэй.
Холимог шинжтэй	Ерөнхийлөгч шүүхийн зөвлөл, хууль тогтоох байгууллагын оролцоотойгоор шүүгчийг томилно.
Бэлгэдлийн шинжтэй	Шийдвэрийг өөр эрх бүхий этгээд гаргаж, Төрийн тэргүүн ёсчлон томилно. Ерөнхийлөгч шүүгчийг томилохоос татгалзах, буцаах эрхгүй, гагцхүү санал болгосон хүрээнд томилно.

## Хүснэгт 13. Ерөнхийлөгч/Төрийн тэргүүний шүүгчгч томилох эрх хэмжээний хэлбэр

Улсын нэр	Ерөнхийлөгч/Төрийн тэргүүний оролцоо	Эрх хэмжээний хэлбэр
АНУ <sup>66</sup>	Холбооны шүүгчдийг томилно; Сенат батламжилсан байхыг шаардана.	Шийдвэрлэх шинжтэй
Энэтхэг <sup>67</sup>	Давж заалдах болон Дээд шүүхийн шүүгчийг Коллегийн санал болгосноор томилно.	Холимог шинжтэй
Пакистан <sup>68</sup>	Шүүхийн хорооны санал болгосноор дээд шатны шүүхийн шүүгчийг томилно.	Холимог шинжтэй
ХБНГУ <sup>69</sup>	Хороо шалгаруулмагц Холбооны Ерөнхийлөгч ёсчлон томилно.	Бэлгэдлийн шинжтэй Холимог шинжтэй

<sup>66</sup> АНУ-ын Үндсэн хуулийн II зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад “Ерөнхийлөгч Сенатын зөвшилцөж, батламжилснаар ... Дээд шүүхийн шүүгчийг томилох бүрэн эрхтэй” гэж заасан. <[https://constitution.congress.gov/browse/essay/artII-S2-C2-2-2/ALDE\\_00001149/](https://constitution.congress.gov/browse/essay/artII-S2-C2-2-2/ALDE_00001149/)> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

<sup>67</sup> Энэтхэгийн Үндсэн хуулийн 124 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Дээд шүүхийн бүх шүүгчийг Ерөнхийлөгч томилно” гэж заасан бөгөөд шүүхээс байгуулсан коллеги (зөвлөгөөн)-ийн санал болгосноор томилдог байна. <<https://doj.gov.in/memorandum-of-procedure-of-appointment-of-supreme-court-judges/>> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

<sup>68</sup> Пакистаны Үндсэн хуулийн 175А-д зааснаар Шүүхийн комисс/Парламентын хорооноос нэр дэвшүүлж, санал болгосноор Ерөнхийлөгч томилно. <<https://www.pakistani.org/pakistan/constitution/part7.ch1.html?utm>> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

<sup>69</sup> ХБНГУ-ын Үндсэн хуулийн 60(1)-д зааснаар Холбооны шүүгчийг Холбооны улсын Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө. Мөн тус зүйлийн 60(3)-т Ерөнхийлөгч тус бүрэн эрхээ бусад байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлж болохоор хуульчилсан. <[https://www.gesetze-im-internet.de/englisch\\_gg/englisch\\_gg.html?utm](https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html?utm)> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

Улсын нэр	Ерөнхийлөгч/Төрийн тэргүүний оролцоо	Эрх хэмжээний хэлбэр
Франц <sup>70</sup>	Шүүхийн дээд зөвлөлийн оролцоотойгоор дээд шатны шүүхийн шүүгчийг томилно.	Холимог шинжтэй
Өмнөд Африк <sup>71</sup>	Шүүхийн үйлчилгээний хорооны зөвлөснөөр шүүгчийг томилно.	Холимог шинжтэй
ОХУ <sup>72</sup>	Холбооны хэмжээнд шүүгчийг томилно, дээд шатны шүүхийн шүүгчийг Холбооны зөвлөлийн оролцоотойгоор томилно.	Шийдвэрлэх шинжтэй
Бразил <sup>73</sup>	Холбооны Дээд шүүхийн шүүгчийг томилно, Сенат батламжилсан байхыг шаардана.	Холимог шинжтэй
Филиппин <sup>74</sup>	Хуульчдын болон Шүүхийн зөвлөлөөс хүргүүлсэн жагсаалтаас томилно.	Холимог шинжтэй
Итали <sup>75</sup>	Шийдвэрийг Шүүхийн ерөнхий зөвлөл гаргаж, Ерөнхийлөгч ёсчлон томилно.	Бэлгэдлийн шинжтэй
Австри <sup>76</sup>	Засгийн газар, шүүхийн байгууллагын зөвлөснөөр шүүгчийг томилно.	Бэлгэдлийн шинжтэй

<sup>70</sup> Франц улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлд “Шүүхийн байгууллагын бие даасан байдлын баталгааг хангагч нь Ерөнхийлөгч байна”, мөн хуулийн 65 дугаар зүйлд “Шүүхийн дээд зөвлөл нь Дээд шүүхийн шүүгч, Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчид томилуулахаар санал болгох бүрэн эрхтэй. Бусад шүүхийн шүүгчийг энэ зүйлд зааснаар зөвшилцөж томилно” гэж заасан. <<https://www.conseil-constitutionnel.fr/en/constitution-of-4-october-1958>> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

<sup>71</sup> Өмнөд Африкийн Үндсэн хуулийн 174 дүгээр зүйлийн (3), (7)-д зааснаар Ерөнхийлөгч Шүүхийн үйлчилгээний хорооны саналд үндэслэж шүүгчийг томилно. <<https://www.justice.gov.za/constitution/SACConstitution-web-eng.pdf>> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

<sup>72</sup> ОХУ-ын 128 дугаар зүйлийн 1, 2-т зааснаар Дээд шүүхийн шүүгчийг Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Холбооны зөвлөл, бусад шүүхийн шүүгчийг Ерөнхийлөгч томилно. <<http://www.constitution.ru/en/10003000-08.htm>> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

<sup>73</sup> Бразилын Үндсэн хуулийн 84 дүгээр зүйлийн XIV-д зааснаар Сенатын батламжилснаар Дээд шүүхийн шүүгчийг томилох, XVI зүйлд зааснаар бусад шүүхийн шүүгчдийг томилно. <<https://www.globalhealthrights.org/wp-content/uploads/2013/09/Brazil-constitution-English.pdf>> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

<sup>74</sup> Филиппин улсын Үндсэн хуулийн VIII зүйлийн 9-д “Дээд шүүх, бусад шүүхийн шүүгчийг Шүүх, хуульчдын зөвлөлөөс гаргасан гурваас доошгүй нэр дэвшигчээс Ерөнхийлөгч томилно” гэж заасан. <<https://www.officialgazette.gov.ph/constitutions/1987-constitution/>> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

<sup>75</sup> Италийн Үндсэн хуулийн 105 дугаар зүйлд зааснаар шүүгч томилох, шилжүүлэх, дэвшүүлэх, чөлөөлөх чиг үүргийг Шүүхийн дээд зөвлөл гүйцэтгэнэ. Ерөнхийлөгч тус зөвлөлийн тэргүүний үүргийг гүйцэтгэдэг ч зөвлөл нь бие даасан байдлаар ажиллаж шийдвэрлэдэг тул энд бэлгэдлийн шинжтэйд хамааруулав. <[https://www.senato.it/documenti/repository/istituzione/costituzione\\_inglese.pdf](https://www.senato.it/documenti/repository/istituzione/costituzione_inglese.pdf)> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

<sup>76</sup> Австрийн Үндсэн хуулийн 86 дугаар зүйлд зааснаар Засгийн газрын санал болгосноор Ерөнхийлөгч шүүгчийг томилно. Гэвч гагцхүү Засгийн газраас санал болгосон жагсаалтаас томилох тул бэлгэдлийн шинжтэйд хамаарахаар байна. <[https://constitutionnet.org/sites/default/files/Austria%20\\_FULL\\_%20Constitution.pdf](https://constitutionnet.org/sites/default/files/Austria%20_FULL_%20Constitution.pdf)> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

Улсын нэр	Ерөнхийлөгч/Төрийн тэргүүний оролцоо	Эрх хэмжээний хэлбэр
Ирланд <sup>77</sup>	Засгийн газар болон Шүүхийн томилгооны зөвлөх зөвлөлийн зөвлөснөөр ёсчлон томилно.	Бэлгэдлийн шинжтэй
ИБУИНХУ <sup>78</sup>	Ерөнхий сайд, Шүүхийн томилгооны хорооны зөвлөснөөр Эзэн хаан/хатан ёсчлон томилно.	Бэлгэдлийн шинжтэй
Япон <sup>79</sup>	Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Засгийн газрын шийдвэрлэснээр Эзэн хаан ёсчлон томилно.	Бэлгэдлийн шинжтэй

Дээрхээс үзвэл улсуудын Үндсэн хуульд шүүгч томилох зохицуулалттай холбоотой хэсгийг хуульчлахдаа тухайн улсын шүүхийн зөвлөл болон бусад эрх бүхий байгууллагын санал болгосноор Ерөнхийлөгч томилох тухай зааснаас ямар шалгуураар томилох, татгалзвал хэрхэх талаар үгчлэн заагаагүй нь нийтлэг ажиглагдлаа.

Иймд органик хууль болон бусад хуулиар тус асуудлыг зохицуулж байх боловч энэхүү эрх зүйн тодорхойгүй байдал өөрөө асуудал үүсгэдгийг Польш Улсад болсон тохиолдлоос харж болохоор байна. Тодруулбал, Польш Улсын Үндсэн хуулийн 179 дүгээр зүйлд “Шүүгчийг Шүүхийн үндэсний зөвлөлийн санал болгосноор Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч томилно”<sup>80</sup> гэж заасан бөгөөд Ерөнхийлөгч санал болгосон

<sup>77</sup> Ирландын Үндсэн хуулийн 35 дугаар зүйлийн 1-д зааснаар “Дээд шүүх, давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Ерөнхийлөгч томилно” гэх боловч мөн хуулийн 13.9-д “Ерөнхийлөгч бүрэн эрхээ гагцхүү Засгийн газрын зөвлөмжид үндэслэн хэрэгжүүлнэ” гэж заасан. 1995 оноос хойш Шүүхийн томилгооны зөвлөх зөвлөл хэмээх байгууллага Засгийн газарт нэрсийн жагсаалтыг хүргүүлдэг болсон хэдий ч Засгийн газар тус жагсаалтыг заавал дагаж мөрдөх албагүй, мөн Ерөнхийлөгч шүүгчийг томилохоос татгалзах эрхгүй тул Ерөнхийлөгчийн бүрэн эрх бэлгэдлийн шинжтэй.  
<<https://www.irishstatutebook.ie/eli/cons/en/html#part11>> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

<sup>78</sup> ИБУИНХУ нь бичмэл Үндсэн хуульгүй хэдий ч 2005 онд баталсан “Үндсэн хуулийн шинэтгэлийн тухай хууль”-ийн 61 дүгээр зүйлээр Шүүхийн томилгооны хороо байгуулсан бөгөөд тус байгууллага нэр дэвшигчийг санал болгохоор Лорд Канцлерт нэрийг нь хүргүүлснийг Лорд Канцлер Ерөнхий сайдад уламжилна. Улмаар Эзэн хаан/хатан ёсчлон томилох ба тус бүрэн эрх бүхэлдээ бэлгэдлийн шинжтэй.  
<<https://www.legislation.gov.uk/ukpga/2005/4/contents>> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

<sup>79</sup> Японы Үндсэн хуулийн (6)1, 79, 80 дугаар зүйлд тус тус зааснаар Дээд шүүхийн шүүгчийг Засгийн газар, доод шатны бусад бүх шүүхийн шүүгчийг Дээд шүүхийн санал дэвшүүлсэн жагсаалтаас Засгийн газар, Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн Засгийн газрын шийдвэрлэснээр Эзэн хаан томилно. Ингэхдээ Эзэн хаан гагцхүү ёсчлон томилох тул бүхэлдээ бэлгэдлийн шинжтэй.  
<[https://japan.kantei.go.jp/constitution\\_and\\_government\\_of\\_japan/constitution\\_e.html](https://japan.kantei.go.jp/constitution_and_government_of_japan/constitution_e.html)> (Сүүлд үзсэн: 2025.09.25).

<sup>80</sup> Польш улсын Үндсэн хууль, SEJM, <<https://www.sejm.gov.pl/prawo/konst/angielski/kon1.htm>> (Сүүлд үзсэн: 2025.09.23).



- тухайн тохиолдолд холбогдох хууль тогтоомжоор Ерөнхийлөгчийн шийдвэрээс үүдэлтэй хэрэгжүүлэх аливаа эрхийг нэр дэвшигчдэд олгоогүй;
- шүүгч томилох асуудлаар гаргасан Ерөнхийлөгчийн шийдвэрийн эсрэг давж заалдах гомдлыг шийдвэрлэх нь захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамаарах эсэх талаар хууль тогтоомжоор зохицуулаагүй тул нэр бүхий гомдол гаргагчдын “шүүхэд хандах эрх зөрчигдсөн” гэх гомдол үндэслэлгүй гэж үзлээ. Үндсэн хуулиар баталгаажсан “шүүхэд хандах эрх” гагцхүү шүүхийн харьяалалд хамаарах асуудалд үйлчилнэ ... Захиргааны шүүхийн хяналт гагцхүү төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаагаар хязгаарлагддаг. ... Энэ утгаараа, “шүүхэд хандах эрх” гэх ойлголт нь зөвхөн тухайн этгээдийн нөхцөл байдалд нөлөөлөхүйц захиргааны байгууллагын шийдвэрийг захиргааны шүүх харьяалан шийдвэрлэх эсэхэд эргэлзээ үүссэн тохиолдолд хамаарна. Өөрөөр хэлбэл, тус тохиолдолтой төстэй нөхцөл байдалд, Үндсэн хуулийн 45 дугаар зүйлийг гагцхүү захиргааны шинжтэй асуудалд, захиргааны шүүхийн харьяалалд хамаарах тохиолдолд хэрэглэх боломжтой;
- Ерөнхийлөгч шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчийг томилохоос татгалзсан тохиолдолд нэр дэвшигч захиргааны хэргийн шүүхэд эс зөвшөөрч гомдол гаргах эрхийг Европын Хүний эрхийн Конвенцийн 6 дугаар зүйлээр баталгаажуулаагүй. Конвенцийн агуулгаар “шүүхэд хандах эрх” гэх ойлголт гагцхүү тус 6 дугаар зүйлд хамаарах захиргааны шийдвэрийн эсрэг хэрэглэгдэнэ. Хэдий тодорхой нөхцөлд тус зүйлийн хүрээнд албан тушаалтан (шүүгч хамаарна)-ыг хамааруулан хэрэглэх боломжтой боловч шүүгчийн гагцхүү чиг үүргээ гүйцэтгэх явцад үүссэн иргэний буюу хувийн шинжтэй асуудал үүссэн тохиолдолд хамаарна;
- Дээр дурдсанчлан гомдол гаргагчдын тус гомдлыг хэлэлцэх нь захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамааралгүй тул Ерөнхийлөгчийн гаргасан маргаан бүхий шийдвэр үндэслэлтэй эсэхийг шалгах шаардлагагүй гэж үзлээ.

Хэдий дээрх нэр дэвшигчдийн гомдлыг Польш Улсын дотоодын шүүх хүлээж аваагүй боловч Европын Хүний эрхийн шүүхээс Европын Хүний эрхийн Конвенцийн 6, 8 дугаар зүйлд заасан эрхийг зөрчсөн байж болзошгүй байна гээд хүлээн авч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа аж.<sup>85</sup> Тус маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа боловч Польшийн төдийгүй Европын холбооны хүрээнд маргааны агуулгын талаар дараах хүлээлт бий болж байна гэж болох юм:

- Ерөнхийлөгч үндэслэл, шалтгаанаа тайлбарлахгүйгээр шүүгч томилохоос татгалзаж болох эсэх буюу Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн цар хүрээг тодорхой болгох;
- Өндөр оноо авсан нэр дэвшигчдийг томилохоос татгалзсаны улмаас шүүгчээр томилогдож чадаагүй нь тэдний эрхийг зөрчсөн

<sup>85</sup> ibid.

эсэх, зөрчигдсөн эрхийг хэрхэн сэргээх, нөхөр төлбөр олгох эсэхийг шийдвэрлэх.

Польш Улсын шүүгч томилохтой холбоотой Үндсэн хуулийн зохицуулалт, практикт гарч байгаа асуудал Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, практиктай ижил байгааг мөн дараах тохиолдлоос харж болохоор байна.

*Хүснэгт 15. Шүүгчийн томилгоотой холбоотой Ерөнхий зөвлөл,  
Ерөнхийлөгчид холбогдох захиргааны хэргүүд*

**Тохиолдол 1:** Хариуцагч Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлбараас үзэхэд 2013 оны Шүүх байгуулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2013 оны 41 дүгээр тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчдийг албан тушаалаас нь чөлөөлүүлэх саналыг, 2013 оны 42 дугаар тогтоолоор дээрх ерөнхий шүүгч, шүүгчдийг шинээр байгуулагдсан шүүхэд буцаан томилуулах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид тус тус өргөн мэдүүлж, улмаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 198 дугаар зарлигаар анхан болон давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчдийг чөлөөлж, 2013 оны 199 дүгээр зарлигаар ерөнхий шүүгч, шүүгчдийг буцаан томилохдоо шүүгчээр ажиллаж байсан нэхэмжлэгч 12 иргэнийг томилоогүй орхигдуулсан байна.

Нэхэмжлэгч 12 иргэн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 1/ нэхэмжлэгч нарыг холбогдох шүүхийн шүүгчээр томилуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхийг Шүүхийн ерөнхий зөвлөлд даалгах, 2/ Монгол Улсын Ерөнхийлөгчид холбогдуулан нарыг нарыг өөрчлөн байгуулсан шүүхийн шүүгчээр буцаан томилоогүй орхигдуулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, тэдгээрийг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2-т нийцүүлэн урд эрхэлж байсан шүүгчийн албан тушаалд буцаан томилох шийдвэрээ гаргахыг Монгол Улсын Ерөнхийлөгчид даалгах” шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргасан.

Шүүх нэхэмжлэгч нарын 1 дэх шаардлагыг хангаж, 2 дахь шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, Ерөнхийлөгчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон. Ингэхдээ: “Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно. гэж заасан байна. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтаас үзэхэд шүүгчийг томилох бүрэн эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгчид Үндсэн хуулиар олгосон байх ба Монгол Улсын Ерөнхийлөгчид бүх шатны шүүгчдийг томилох бүрэн эрх олгосон эрх зүйн үндсэн эх сурвалж нь Монгол Улсын Үндсэн хууль байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Ерөнхийлөгч шүүгчдийг томилохтой холбоотой харилцааг Үндсэн хуулийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулсан байна.

Иймд нэхэмжлэгч Д.А нарын 2 дах нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой харилцааг Үндсэн хуулийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулсан байх бөгөөд шүүгчдийг томилохтой холбоотой бүрэн эрхийг Монгол улсын Ерөнхийлөгчид Монгол Улсын Үндсэн хуулиар олгосон байх тул маргаан бүхий энэ тохиолдолд Монгол улсын Ерөнхийлөгч буюу төрийн тэргүүний институтыг захиргааны байгууллага гэж үзэхээргүй байна” гэж дүгнэжээ.<sup>86</sup>

**Тохиолдол 2:** Дээрх маргааны хүрээнд гаргасан шүүхийн шийдвэрийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Б.О-г шүүгчээр томилуулах саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн боловч Ерөнхийлөгчийн 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн Е/05 дугаар албан бичгээр нэр бүхий 6 нэр дэвшигчийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.5 дахь заалтад заасан болзол шаардлагыг хангахгүй байна” гэсэн үндэслэлээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг буцаан хүргүүлсэн” байна. Б.О дахин захиргааны хэргийн шүүхэд хандаж хэд хэдэн нэхэмжлэлийн шаардлага гаргасны нэгээ “Монгол Улсын Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн Е/04, 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн Е/05 дугаар санал буцаан хүргүүлэх тухай шийдвэрийг тус тус хууль бус болохыг тогтоож, шүүгчээр томилохыг Монгол Улсын Ерөнхийлөгчид даалгах” гэж тодорхойлсон.

**Шүүх** нэхэмжлэлийн энэ шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгохдоо “Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт ... бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно..., Жаран зургаадугаар зүйлийн 2. Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их хуралд оруулна: 1/ ... Ерөнхийлөгчийн бусад шийдвэр... Монгол улсын Олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх гэж заасан. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг тусгасан байх бөгөөд Үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэн гаргасан шийдвэрээс шүүгчийг томилохгүй байгаа шийдвэр-ийг тусгайлан ялган шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан гэж үзэх боломжгүй болох нь дээр дурдсан хуулийн заалтуудаас харагдана. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгосон онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлж гаргасан шийдвэр нь Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан юм. Түүнчлэн Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд захиргааны байгууллагыг төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас эхлэн эрэмбэ дараагаар нь жагсааж, хууль тогтоогчоос тусгаж өгсөн, 5.4-т Нийтийн эрх зүйн асуудлаар бие даан, өөрийн нэрийн өмнөөс дангаар захиргааны шийдвэр гаргах бүрэн эрх хуулиар тусгайлан олгогдсон албан тушаалтныг захиргааны байгууллага гэж үзнэ, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ гэж тус тус зааснаас үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгчийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлэн шийдвэр гаргаж байгаагийнх нь хувьд захиргааны байгууллага гэж үзэхгүй.

<sup>86</sup> Д.А нарын 12 иргэний нэхэмжлэлтэй Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Ерөнхийлөгчид холбогдох захиргааны хэрэг. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр. 2022.02.08, 128/ШШ2022/0070 [https://shuukh.mn/single\\_case/8986?daterange=2022-01-01%20-%202025-12-11&id=1&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/8986?daterange=2022-01-01%20-%202025-12-11&id=1&court_cat=3&bb=1)

Өмнө нь энэ талаар дүгнэсэн шүүхийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байна” гэж дүгнэсэн.<sup>87</sup> Шүүхийн энэ шийдвэрийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хэвээр үлдээсэн<sup>88</sup>

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгч Ерөнхий зөвлөлийн санал болгосноор шүүгчдийг томилдог боловч Ерөнхийлөгч Ерөнхий зөвлөлөөс санал болгосон хүнийг томилохоос тагалзах эрхтэй эсэх талаар тодорхой заагаагүй. Шүүгчийн томилгооны хүрээнд Ерөнхий зөвлөл ба Ерөнхийлөгчийн хооронд үүсдэг энэхүү харилцааг өнгөрсөн хугацаанд дараах байдлаар зохицуулж иржээ:

**Шүүхийн тухай хууль (1993 он):** §6.8.Ерөнхий шүүгч болон шүүгчээр томилуулахаар санал болгосон хүнийг Ерөнхийлөгч татгалзвал Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр хүнийг санал болгоно.

**Шүүхийн тухай хууль (2002 он):** §32.8.Ерөнхий шүүгч болон шүүгчээр томилохоос Ерөнхийлөгч татгалзсан тохиолдолд Ерөнхий зөвлөл Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгоно.

**Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012 он):** §15.2.Ерөнхийлөгч Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигчийг судлан үзэж, түүнийг томилох буюу томилохоос татгалзах шийдвэрийн аль нэгийг гаргана.

**Дагаж мөрдөж буй Монгол Улсын шүүхийн тухай хууль (2021 он):** §36.4.Ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигч энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан шүүгчид тавих болзол, шаардлага хангаагүй гэж үзвэл Ерөнхийлөгч энэ тухай Ерөнхий зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ. §36.5.Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчийн саналыг дахин нягталж, томилохоос татгалзсан үндэслэл тогтоогдоогүй тохиолдолд тухайн нэр дэвшигчийг дахин санал болгох, нотлогдсон тохиолдолд Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгоно.

<sup>87</sup> Б.О-ийн нэхэмжлэлтэй, Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Ерөнхийлөгчид холбогдох захиргааны хэрэг. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр. 2023.03.10, 128/ШШ2023/0201 [https://shuukh.mn/single\\_case/12682?daterange=2022-01-01%20-%202025-12-11&id=1&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/12682?daterange=2022-01-01%20-%202025-12-11&id=1&court_cat=3&bb=1)

<sup>88</sup> Б.О-ийн нэхэмжлэлтэй, Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Ерөнхийлөгчид холбогдох захиргааны хэрэг. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал. 2023.04.26, 221/МА2023/0278 [https://shuukh.mn/single\\_case/5832?start\\_date=&end\\_date=&id=2&court\\_cat=3&bb=1](https://shuukh.mn/single_case/5832?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1)

Дээрх хуулиудын зохицуулалтаас үзэхэд 2021 он хүртэл Ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигчийг томилохоос татгалзах Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлах үндэслэлийн талаар зохицуулаагүй, Ерөнхийлөгч үзэмжээрээ шийдвэрлэж байсан<sup>89</sup> бөгөөд нэгэнт Ерөнхийлөгч Ерөнхий зөвлөлөөс санал болгосон хүнийг шүүгчээр томилохоос татгалзсан л бол Ерөнхий зөвлөл тухайн хүнийг дахин санал болгох боломжгүй, нэр дэвшигч үүний эсрэг маргах боломж огт байхгүй байсан.

*Хүснэгт 16. Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоолын үндэслэл*

**Тохиолдол.** 1998 онд нэгэн иргэн Үндсэн хуулийн цэцэд “Миний бие шүүгчийн сонгон шалгаруулалтад орж тэнцэн, улмаар намайг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс олонхын саналаар ... шүүгчийн албан тушаалд томилуулахаар Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн. Гэвч Ерөнхийлөгч намайг шүүгчээр томилох боломжгүй гэсэн хариуг өгсөн. Ерөнхийлөгч Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгон хүнийг буцааж байгаа нь хууль зөрчсөн үйл ажилагаа гэж үзэж байна” гэсэн агуулгатай өргөдөл гаргажээ.

Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 47 дугаар тогтоолоор “Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 8-д “Ерөнхий шүүгч болон шүүгчээр томилуулахаар санал болгосон хүнийг Ерөнхийлөгч татгалзвал Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр хүнийг санал болгоно” гэж хуульчилсан байна. Иймд шүүгчээр томилохоос татгалзсан Ерөнхийлөгчийн шийдвэрийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна” гээд маргаан үүсгэхээс татгалзсан. Үндсэн хуулийн цэцийн гишүүний энэ тогтоолыг Үндсэн хуулийн бага суудлын хуралдааны 1999 оны 01 дүгээр магадлаар хэвээр үлдээсэн байна.

Хэдийгээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн шүүгч томилох эрх нь “бэлгэдлийн шинжтэй”, тийм байх ёстой гэж үзэх судлаачид байдаг боловч Үндсэн хуулийн зохицуулалт, өнгөрсөн хугацааны практикаас үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн шүүгч томилох эрхийн зохицуулалт “бэлгэдлийн” төдий биш харин “холимог шинжтэй” байна.

Харин Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4-т “Ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигч энэ хуулийн 31 дүгээр

<sup>89</sup> Уг асуудлыг Үндсэн хуулийн түвшинд шийдвэрлэхээр 2019 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн анхны төсөлд “Шүүхийн ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн шүүгчийг томилох шийдвэрээ Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Ерөнхийлөгч энэ шийдвэрийг хүлээн авснаас хойш хорин нэг хоногийн дотор батламжилна. Үндсэн хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзвэл Ерөнхийлөгч шүүгчийг батламжлахаас татгалзаж, үндэслэлээ нийтэд мэдээлнэ” гэж тусгасан байсан боловч батлагдаагүй. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн анхны төслийг дараах линкээр орж үзнэ үү. <http://forum.parliament.mn/projects/612>

зүйлд заасан шүүгчид тавих болзол, шаардлага хангаагүй гэж үзвэл Ерөнхийлөгч энэ тухай Ерөнхий зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ”, 36.5-д “Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчийн саналыг дахин нягталж, томилохоос татгалзсан үндэслэл тогтоогдоогүй тохиолдолд тухайн нэр дэвшигчийг дахин санал болгох, нотлогдсон тохиолдолд Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгоно” гэж зааснаараа Ерөнхийлөгчийн үзэмжийг тодорхой хэмжээнд хязгаарлаж, мөн Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийг дахин өргөн мэдүүлэх боломжтой болгосноороо ач холбогдолтой зохицуулалт болсон.

### *Хүснэгт 17. Ерөнхийлөгчөөс буцаасан нэр дэвшигчийн тоон мэдээлэл*

**Тоон мэдээ.** Ерөнхий зөвлөлийн ажлын албанаас “2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар нийт өргөн мэдүүлсэн 163 нэр дэвшигчээс 31 нэр дэвшигчийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан шүүгчид тавих болзол, шаардлага хангаагүй гэх үндэслэлээр буцаасан. Буцаасан нэр дэвшигчээс 6 нэр дэвшигчийг дахин өргөн мэдүүлснээр томилогдсон, 16 нэр дэвшигчийг дахин өргөн мэдүүлсэн”<sup>90</sup> гэсэн тоон мэдээлэл өгсөн.

**Ерөнхий зөвлөлийн хуралдааны тойм.** Ерөнхий зөвлөлийн 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр болсон хуралдаанаар 2025 оны 198, 200, 202, 203, 206, 209, 210, 212 дугаар тогтоолоор давж заалдах шатны шүүхийн шүүгчээр томилуулахаар дахин санал болгосон шүүгч Хасбаатарын Ганболд, Баяраагийн Батаа, Бат-Очирын Өлзийхишиг, Жаргалын Дэлгэрмөрөн, Халамханы Мейрамбек, Бавуугийн Цэрэнханд, Сарантуяагийн Ганбат, Чинзоригийн Баярмаа нарыг Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны Е/07, Е/08 дугаар албан бичгээр “Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.5 дахь заалтад заасан болзол, шаардлагыг хангахгүй” үндэслэлээр саналыг тус тус буцаан ирүүлсэн ба буцаасан үндэслэлийг нягтлан, эрх бүхий байгууллагуудаас лавлагаа, мэдээлэл авсаны үндсэнд давж заалдах шатны шүүгчид тавин шаардлагыг хангахгүй гэх үндэслэл тогтоогдоогүй болохыг хэлэлцээд дахин өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн”<sup>91</sup> гэжээ.

Өмнөх эрх зүйн зохицуулалтаар Ерөнхий зөвлөлөөс нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлээгүй тохиолдолд нэр дэвшигч үүнтэй маргах, маргалаа ч амжилт олох боломжгүй байсан. Учир нь Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгох эсэхийг санал хураалтаар шийдвэрлэдэг байсан тул үүнтэй холбоотой гаргасан шийдвэрийг шүүхээс эрх зүйн хүрээнд хянах боломжгүй байсан юм. Харин Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4,

<sup>90</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлөөс авсан тоон мэдээлэл.

<sup>91</sup> [https://www.judcouncil.mn/site/news\\_full/15380](https://www.judcouncil.mn/site/news_full/15380)

36.5-д заасан зохицуулалтын хүрээнд Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийг үнэлгээний эрэмбийн дагуу өргөн мэдүүлээгүй, эсхүл Ерөнхийлөгчөөс нэр дэвшигчийг буцаасан үндэслэлийг нягтлан шалгаж дахин өргөн мэдүүлээгүй нь хууль бус гэж үзвэл үүний эсрэг маргах боломжтой болсон байна.

Гэсэн хэдий ч шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт 2023 оны 11 дүгээр сарын 6-15-нд Монгол Улсад айлчилсны үр дүнд гаргасан “Урьдчилсан дүгнэлтийн танилцуулга”-даа Шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйл, Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан шүүгчийг томилох тухай саналыг буцаах бүрэн эрх нь хэтэрхий өргөн цар хүрээтэй байгааг онцгойлон тэмдэглэж байна. Ерөнхийлөгчийн энэхүү бүрэн эрх нь эрх мэдлийн хуваарилалтын хараат бус байдалд нөлөөлөх эсхүл тус улсын ихээхэн анхаарал хандуулж ирсэн шүүх тогтолцоонд нэр дэвшигчийг томилуулан ажиллуулах замд саад учруулахгүй байх эрсдэлийг арилгахад дараа дараачийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна” гэснийг анхаарах нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгчийн буцаасан нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөл дахин өргөн мэдүүлсэн тохиолдолд хэрхэх буюу Ерөнхийлөгч уг нэр дэвшигчийг дахин буцаах, эсхүл шууд томилох эсэхийг Монгол Улсын шүүхийн тухай хуульд тодорхой заагаагүй байна.

## Найм. Шүүгчийн сонгон шалгаруулалтын нээлттэй, ил тод байдал

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Хуульчдаас шүүгчийг шилж олох, сонгон шалгаруулах, шүүгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх ажлыг Ерөнхий зөвлөл нээлттэй, ил тод, хараат бус байх, хууль дээдлэх зарчмыг баримтлан зохион байгуулна” гэж заасан.


Гэвч шүүгчид нэр дэвшигчдийн тайлбарын дагуу шүүгчийн нэр дэвшигчийн шалгалтын үр дүн, шалгалт бэлтгэх үндэслэл, удирдамжийн ил тод байдал, гомдол гаргах боломж хангалтгүй байгаа талаар хөндөж байна.

**Шүүгчид нэр дэвшигч:** “Миний хувьд Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгчийн шалгалт өгсөн. Тестийн хоёр шалгалт өгсөн. Харин тестийн шалгалт дууссаны дараа зөвхөн хэдэн оноо авсныг мэдэгдсэн бөгөөд аль тестийг алдсан, аль тестийг зөв хийсэн талаар мэдэгдээгүй. Эрх зүйн баримт бичиг боловсруулах даалгаврыг дотроо сайн хийлээ гэж бодсон боловч нэлээд оноо алдсан. Яг юуг дутуу хийснээ ойлгоогүй. Эрх зүйн тохиолдол шийдвэрлэх шалгалт дээр бодолтын хариуг хэлдэггүй юм байна лээ. Шүүгчийн шалгалт эхлэх үед цаашдаа шалгалтын хариуг мэдэгддэг болно гэж хэлж байсан. Ер нь бүх шалгалт дээр зөв хариулт, үр дүнг тодорхой мэдэгдэхгүй, яагаад бага оноо авсныг мэдэхгүй байгаа нь ойлгомжгүй санагдсан.

Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагаас

**Асуумж.** Асуулгад оролцогчид “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүгчид нэр дэвшигчдэд өгч байгаа удирдамж, заавар, дэмжлэг хэр хангалттай, ойлгомжтой” эсэх талаар дараах хариултыг өгсөн байна. Тодруулбал,

шүүгчийн сонгон шалгаруулалтын удирдамж, даавар, дэмжлэг дунд зэрэг буюу хангалтгүй гэсэн хариулт дийлэнх хувийг эзэлжээ.




Тестийн хариуны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүйгээр гагцхүү “оноог мэдэгдэхээс өөрөөр юун дээр алдсаныг мэдэгдэхгүй” гэх хандлага баримтлах нь зохисгүй юм. Мөн эрх зүйн тохиолдол шийдвэрлэх даалгаврын бодолтын хариу, зөв шийдлийг мэдэгдэхгүй байх нь учир дутагдалтай. Учир нь энэ хэсэгт шүүгчид нэр дэвшигчийн онол, практикийн мэдлэг, хууль хэрэглэх, хууль зүйн дүгнэлт хийх чадварыг үнэлдэг тул зөв хариулт, шийдлийг мэдэгдэхгүй байх нь шударга бус байдал үүсгэж, хардлага бий болох үндэс болох билээ. Нөгөө талаас шүүгчид нэр дэвшигчийн шалгалтын даалгаврын зөв шийдэл, хариуг нэр дэвшигчид мэдэгдэхгүй байгаа нь нэр дэвшигчийн өөрийгөө дүгнэх, алдаанаасаа суралцах, өөрийгөө хөгжүүлж, шалгалтад дахин бэлтгэх боломжийг бууруулж байгаа хэрэг юм.


Гэтэл Ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ыг 5.4.3-т “Ерөнхий зөвлөлийн гишүүн эрх зүйн тохиолдол шийдвэрлэх, эрх зүйн баримт бичиг боловсруулах, хууль тайлбарлан хэрэглэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргаар авсан шалгалтын хариуг үнэлэхдээ тухайн шалгалтын даалгаврыг зохиосон Ерөнхий зөвлөлийн гишүүн, эсхүл хөндлөнгийн хараат бус шинжээчийн хариулт, аргачлалыг баримтална” гэж, мөн Ерөнхий зөвлөлийн 2022 оны 76 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчийн сонгон шалгаруулалтын зохион байгуулах аргачлал”-ын “Ес. Шалгалтын даалгавар боловсруулах” хэсэгт “сорилд зөв шийдлийг хавсаргах”, “даалгаварт зөв шийдлийг хавсаргах” шаардлагыг зааснаас үзэхэд шүүгчид нэр дэвшигчийн шалгалтын даалгавар бүр “зөв шийдэл, хариулттай байх”-аар байгааг

анхаарч, тус зохицуулалтуудын хэрэгжилтийг хангах шаардлагатай байна.

Асуумж. Асуулгад оролцогчид “Шүүгчийн сонгон шалгаруулалтын шийдвэр, үр дүнд гомдол гаргах буюу давж заалдах боломж хэр зэрэг бүрдсэн” талаар дараах хариултыг өгсөн байна. Тодруулбал, шүүгчийн сонгон шалгаруулалтын үр дүнг эс зөвшөөрсөн тохиолдолд гомдол гаргах боломж хангалтгүй бүрдсэн гэх хариулт олонх хувьтай байна.




Асуумж. Шүүгчийн сонгон шалгаруулалт нээлттэй, ил тод, аливаа ялгаварлалаас ангид явагддаг (1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлнэ үү. 1 нь маш муу, 5 нь маш сайн гэсэн үр дүнг илтгэнэ) эсэхийг асуулгад оролцогчид дараах байдлаар гэж үнэлсэн байна.



Ерөнхий зөвлөлийн 2022 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ын 8.2-т “Нэр дэвшигч ... сорилын асуулгад хариулах болон эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргаар авсан шалгалтын хариу зөрүүтэй талаар ажлын нэг өдрийн дотор Ерөнхий зөвлөлд бичгээр гомдол гаргах эрхтэй” гэж


заасан. Гэтэл нэр дэвшигчид шалгалтын зөв шийдэл, хариуг мэдэгдээгүй тохиолдолд нэр дэвшигч хэрхэн гомдол гаргах нь тодорхойгүй болох юм.

**Асуумж.** Шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичиг, мэдээлэл хүртээмж (мэдээллийг системчлэн ойлгомжтой, амар хялбараар хайж олохуйц байдлаар олон нийтэд хүргэх)-тэй байдаг (1-ээс 5 хүртэлх оноогоор үнэлнэ үү. 1 нь маш муу, 5 нь маш сайн гэсэн үр дүнг илтгэнэ) эсэхийг асуулгад оролцогчид дараах байдлаар үнэлжээ.



Мэдээллийн хүртээмж нь мэдээллийг зөвхөн цахим хуудаст байршуулаад зогсохгүй, түүнийг системчилсэн, төрөлжсөн, ойлгомжтой, хялбар хайж олохуйц байдлаар хүргэхийг шаарддаг. Харин Ерөнхий зөвлөл цахим хуудастаа шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр оруулахгүй байгааг анхаарах шаардлагатай. Тодруулбал, шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг шүүгчийн сонгон шалгаруулалтын үе шаттай уялдуулан тодорхой категор (ангилал, цэс)-т хуваагаагүй, хэрэглэгчийн интерфэйсийг<sup>92</sup> энгийн, ойлгомжтой байдлаар хангаагүйгээс мэдээллийг хайж олж, ангилахад төвөгтэй байна. Үүнийг шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулж байгаа дараах байдлаас харж болно.

<sup>92</sup> Цахим хуудасны энгийн хэрэглэгчид харагдах байдал.



Өрөнхий зөвлөлөөс шүүгчийн сонгон шалгаруулалтын зар, шүүгчид нэр дэвшигчдийн танилцуулга, нэр дэвшигчдээс шалгалт авах зар, нэр дэвшигчийн үнэлгээ, нэр дэвшигчийг өргөн мэдүүлсэн тухай мэдээллийг тухай бүрд цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр (ихэвчлэн Фэйсбүүк) нийтэд мэдээлж байх боловч шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой олон төрлийн мэдээллийг нэг дор эмх цэгцгүй байршуулсан байгаа нь тухайн мэдээлэл аль сонгон шалгаруулалтын мэдээлэл болохыг тодорхойлоход төвөгтэй байдал үүсгэж байна. Шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг дараах хэлбэрээр системчлэн цахим хуудастаа байршуулбал ойлгомжтой, хялбар болох юм.

*Хүснэгт 18. Шүүгчийн сонгон шалгаруулалтын мэдээллийг цахим хуудаст байршуулах хэлбэрийн талаарх санал*

Сонгон шалгаруулалт	Зарласан сул орон тоо	Бүртгэгдсэн нэр дэвшигч	Тэнцсэн нэр дэвшигч	Өргөн мэдүүлсэн	Томилсон	Томилохоос татгалзсан
Сонгон 1	5	42	10	5	4	1
.....	....	....	....	....	.....	....

### Тайлбар:

**Зарласан сул орон тоо:** Сонгон шалгаруулалт зарласан Ерөнхий зөвлөлийн тогтоол байна.

**Бүртгэгдсэн нэр дэвшигч:** Нэр дэвшигчийг бүртгэсэн Ерөнхий зөвлөлийн тогтоол, хавсралтын хамт байна.

**Тэнцсэн нэр дэвшигч:** Шалгалтын үнэлгээг баталсан Ерөнхий зөвлөлийн тогтоол, тэнцсэн нэр дэвшигчдийн мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга байна.

**Өргөн мэдүүлсэн:** Нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн Ерөнхий зөвлөлийн тогтоол байна.

**Томилсон:** Шүүгчийг томилсон Ерөнхийлөгчийн зарлиг байна.

**Томилохоос татгалзсан:** Ерөнхийлөгчөөс нэр дэвшигчийг буцаасан албан бичиг байна.

Ерөнхий зөвлөл шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг дээрх болон бусад ойлгомжтой хэлбэрээр цахим хуудаст байршуулахгүй байгаагийн улмаас судлаачид шаардлагатай тоон мэдээллийг өөрсдөө тодорхойлж гаргах боломжгүй, зөвхөн Ерөнхий зөвлөлийн өгсөн тоон мэдээлэлд үндэслэхээс өөр аргагүй байна. Нарийвчилсан тоон мэдээллийг Ерөнхий зөвлөлөөс авахаар хандсан боловч тодорхой хариу өгөөгүй, шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой Ерөнхий зөвлөлөөс гарч байгаа эрх зүйн актуудыг манай цахим хуудсаас авах боломжтой гэсэн хариуг өгсөн болно.<sup>93</sup>

Ерөнхий зөвлөл шинээр байгуулагдсанаас хойших хугацаанд Ерөнхийлөгч хэдэн хүнийг шүүгчээр томилсон, хэдэн нэр дэвшигчийн асуудлыг дахин нягтлуулахаар буцаасан, Ерөнхий зөвлөлөөс санал болгосныг огт томилоогүй үлдээсэн хэдэн нэр дэвшигч байгаа талаарх тоон мэдээлэл тодорхойгүй байна.

<sup>93</sup> Албан бичгүүдийг хавсаргав.

Шүүгч томилсон Ерөнхийлөгчийн зарлиг Төрийн мэдээлэл эмхэтгэлд нийтлэгддэг байсан нь больсон байх бөгөөд үүний үндэслэл тодорхойгүй, шүүгч томилсон зарлигийн хуулбарыг Ерөнхий зөвлөлөөс хүсэхэд “шүүгчийг томилсон Ерөнхийлөгчийн зарлигийг албаны нууц баримт бичигт хамааруулсан тул хуулбарлан өгөх боломжгүй” гэсэн хариу өгсөн. Улмаар Ерөнхий зөвлөлийн байранд шүүгч томилсон зарлигтай танилцах хүсэлт гаргасан боловч хариу ирүүлээгүй болно. Мөн Ерөнхийлөгчөөс шүүгчид нэр дэвшигчийг томилохоос татгалзаж, дахин шалгуулахаар буцаасан үндэслэлийг судлах зорилгоор үүнтэй холбоотой баримт бичгийг хуулбарлаж өгөхийг хүссэн боловч мөн албаны нууцад хамааруулсан тул боломжгүй гэсэн хариуг өгсөн.<sup>94</sup> Иймд судалгааны багийн зүгээс энэ асуудалд холбогдуулан харьцуулсан судалгаанаас өөрөөр дүн шинжилгээ хийх, санал дэвшүүлэх боломж байгаагүйг тэмдэглэх нь зүйтэй.

<sup>94</sup> Албан бичгүүдийг хавсаргав.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны үндсэн хэсэгт холбогдох асуудал тухай бүрд хийсэн явцын дүгнэлтээ давтан нуршихгүйгээр дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна:

- *Шүүгчид нэр дэвшигчээс шаардах материалтай холбоотойгоор:* Ерөнхий зөвлөлийн шүүгч сонгон шалгаруулахтай холбоотой үндсэн чиг үүргийг “шүүгчийг хуульчдаас шилж олох” хэмээн тодорхой заасан бөгөөд хэдий чинээ олон чадварлаг хуульч нэр дэвшинэ, төдий чинээ чадварлаг шүүгч бий болох магадлал ихсэх юм. Үүний тулд шүүгчийн сонгон шалгаруулалтын зохион байгуулалтын хэлбэр, агуулгын аль аль нь чухал ач холбогдолтой буюу ялангуяа техникийн шинжтэй асуудлыг нэр дэвшигчийг халшраахгүй, чирэгдэл багатай, хялбар байдлаар шийдвэрлэх нь чухал болж байна. Үүний дагуу шүүгчийн сонгон шалгаруулалтад нэр дэвшигчийн бүрдүүлсэн баримт бичгийг цаасан эсхүл цахим хэлбэрийн аль нэгээр авдаг болох шаардлагатай. Мөн шүүгчээр ажиллаж байгаа хүн дээд шатны шүүхэд нэр дэвших тохиолдолд Ерөнхий зөвлөл өөрт хадгалагдаж байгаа баримт, мэдээлэл, мөн шүүгч дээд шатны шүүхэд нэр дэвшихэд “шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадлагаа”-г дахин гаргуулахгүй байх нь зүйтэй бөгөөд энэ талаар Монгол Улсын шүүхийн тухай хууль, холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах.
- *Дээд шатны шүүхэд нэр дэвшигчийг хууль зүйн мэдлэг, чадварыг үнэлэхтэй холбоотойгоор:* Шүүгчээр ажиллаж байгаа/байсан хүн дээд шатны шүүхэд нэр дэвшиж байгаа тохиолдолд нэг удаагийн бичгийн шалгалтыг цөөрүүлж, шүүгчээр ажилласан хугацааны ажлын үр дүн, гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлт болгох нь илүү оновчтой байна. Тодруулбал, үнэлгээ хийх эрх бүхий субъект нь нэр дэвшигчийн хэрэг шийдвэрлэлтийн хувь, шүүхийн шийдвэрийг үндэслэлтэй бичих чадвар, шүүхийн шийдвэрийн чанар (хүчингүй болсон, буцаасан, өөрчлөлт оруулсан, хэвээр үлдээсэн зэргийг харгалзах), нийтлүүлсэн судалгааны бүтээл зэргийг судалж үнэлэх аргыг нэвтрүүлэх.

Мөн шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадварыг шалгах хүрээнд шалгалтын тодорхой хэсгийг (тухайлбал, бичгийн шалгалт) үнэлэх мэргэшсэн хороо, комисс байгуулах. Энэ асуудлаар Монгол Улсын шүүхийн тухай хууль, холбогдох журамт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах.

*Шүүгчид нэр дэвшигчийн ёс зүй, зан төлөвийг үнэлэх шалгууртай холбоотойгоор:* Шүүгчид нэр дэвшигчээр бүртгэгдсэн бус хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад тэнцсэн нэр дэвшигчийн талаар олон нийтээс санал авдаг болох.

Давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн талаар ярилцлага авах хүний тоог 20-оос доошгүй болгох. Ингэхдээ нэр дэвшигчийн талаар задгай хэлбэрээр бус тодорхой бүтэцлэгдсэн асуулт бүхий асуулгыг хуульч, өмгөөлөгч, шүүхийн захиргааны ажилтан, шүүх хуралдааны оролцогчдоос авдаг болох.

Нэр дэвшигчийг ёс зүй, зан төлөвийн үнэлгээнд оролцуулахгүй шууд хасах ноцтой үндэслэл, шалтгааныг тодорхойлон журамлах. Жишээ нь нэр дэвшигч өөрийнхөө талаар Ерөнхий зөвлөлд үнэн зөв мэдээлэл өгөөгүй, худал хэлсэн, бусдыг ялгаварлан гадуурхсан, доромжилсон, бэлгийн дарамт үзүүлж байсан зэрэг ноцтой үйлдлүүд нотлогдвол ёс зүй, зан төлөвийн шалгуурын үнэлгээнээс хасаж болох юм.

Нэр дэвшигчтэй хийх ганцаарчилсан ярилцлагыг олон нийтэд шууд дамжуулах, нээлттэй ярилцлагын хэлбэрээр хэрэгжүүлж байгаа Өмнөд Африкийн туршлагыг судалж, нэвтрүүлэх. Манай улсын тухайд 2021 онд батлагдсан Хүний эрх хамгаалагчийн тухай хуулиар Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүнийг томилоход Хүний эрхийн үндэсний комиссоос байгуулсан ажлын хэсэг нээлттэй сонгог зохион байгуулж, томилдог зохицуулалт үйлчилж байгааг дурдах нь зүйтэй.

- *Нөөцөөс шүүгчид нэр дэвшүүлэхтэй холбоотойгоор:* Шүүгчид нэр дэвшигчийн шалгалтын үнэлгээ тодорхой хугацаанд хүчинтэй байх зохицуулалт нь уг хугацаанд дахин шалгалт өгөхгүйгээр өмнөх үнэлгээгээ тооцуулан шүүгчийн сул орон тоонд нэр

дэвших эрхтэй байх агуулгаар хэрэгжиж ирсэн байна. Тэгвэл 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Ерөнхий зөвлөл тодорхой үндэслэлээр шүүгчийн сул орон тоо гарсан тохиолдолд шинээр сонгон шалгаруулалт зарлахгүйгээр шалгалтын үнэлгээ нь хүчинтэй байгаа нэр дэвшигчдээс үнэлгээний эрэмбийн дагуу нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгох боломжтой болсон. Энэ нь нэг талаас шүүгчийн сул орон тоог шуурхай нөхөх, нөгөө талаас шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй иргэний эрх, ашиг сонирхлын тэнцвэрийг хангах үүднээс шүүгчийн сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлахгүйгээр нөөцөөс шууд нэр дэвшүүлэхтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй, тодорхой болгох шаардлагатай. Үүний тулд шүүгчийн сонгон шалгаруулалтыг жилд тогтмол хугацаанд зохион байгуулж, нөөцийн жагсаалтыг шинэчилж байх, шүүгчид нэр дэвшигчийн нөөцийн оноог хууль зүйн мэдлэг, чадварын оноогоор тооцож, нөөцөд байгаа нэр дэвшигч холбогдох орон тоонд нэр дэвших бүрд мэргэшил, ёс зүй, зан төлөвийг шалгаж, үнэлдэг байх энэ хүрээнд Монгол Улсын шүүхийн тухай хууль, холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах.

- *Ерөнхийлөгчөөс шүүгчийг томилох зохицуулалттай холбоотойгоор:* Өмнөх зохицуулалтаар Ерөнхий зөвлөлөөс шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгч томилохоос татгалзсан тохиолдолд Ерөнхий зөвлөл өөр хүнийг санал болгодог байсан. Тэгвэл Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Ерөнхийлөгч шүүгчид нэр дэвшигчийг шууд томилохоос татгалзахгүй, харин нэр дэвшигч хуульд заасан болзол, шаардлагыг хангаагүй гэж үзвэл Ерөнхий зөвлөл рүү буцааж дахин нягтлуулах, Ерөнхий зөвлөл дахин нягталж, нотлогдохгүй бол нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид дахин санал болгох боломжтой болсон нь дэвшилттэй зохицуулалт байна. Гэвч Ерөнхий зөвлөлөөс дахин санал болгосон нэр дэвшигчийг Ерөнхийлөгч томилохоос татгалзсан тохиолдолд хэрхэх талаарх зохицуулалт байхгүй байна. Иймд энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг дахин сайжруулах.

- *Шүүгчийн сонгон шалгаруулалтын ил тод, хүртээмжтэй байдалтай холбоотойгоор:* Ерөнхий зөвлөлөөс шүүгчийн сонгон шалгаруулалтын мэдээллийн хүртээмжийг сайжруулж, шүүгчийн сонгон шалгаруулалт зарлахаас эхлээд Ерөнхийлөгчийн зарлиг гарах хүртэлх хугацааны бүх үе шатанд гарсан эрх зүйн акт, шийдвэр, шаардлагатай бусад мэдээллийг сонгон шалгаруулалт тус бүрээр нэр дэвшигч, судлаач, олон нийтэд хайлт хийх боломжтойгоор системчилж, төрөлжүүлж цахим хуудастаа байршуулах. Түүнчлэн шүүгчийн сонгон шалгаруулалтад бэлтгэхтэй холбоотой эх сурвалжийн талаарх удирдамж, заавар гаргах.

--ooOoo--

## НОМ ЗҮЙ

### *А. Монгол эх сурвалж:*

1. ЕАБХАБ-ын АИХЭГ “Монгол Улсын шүүхийн тухай, Шүүхийн захиргааны болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өгөх санал, дүгнэлт” (2020).
2. О.Мөнхсайхан, Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт: Шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг сайжруулах нь, (2015).
3. П.Баттулга “Монгол Улсын шүүхийн томилгооны системийг боловсронгуй болгох нь” (2020).
4. П.Баттулга М.Мөнхжаргал, Ж.Хунан “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: Шүүгчийн томилгоо” (2015).

### *Б. Гадаад эх сурвалж:*

1. ABA, Standing Committee on the Federal Judiciary, What It Is and How It Works (July 2025)
2. Austin R Nelson, “Evaluating the Evaluator: Has the ABA Rated President Trump’s Judicial Nominees Fairly?”, 99 Texas Law Review 2020: 194-212.
3. Francois Du Bois, “Judicial Selection in Post-Apartheid South Africa” in Kate Malleson and Peter H Russell (eds), Appointing Judges in an Ages of Judicial Power (University of Toronto Press: Toronto, 2006).
4. Judicial Service Commission, Summary and Explanation of the Criteria and Guidelines Used by the Judicial Service Commission when Considering Candidates for Judicial Appointment.
5. Kyiv Recommendations on Judicial Independence in Eastern Europe, South Caucasus and Central Asia (2010)
6. Maya Sen, “How Judicial Qualification Ratings May Disadvantage Minority and Female Candidates”, 2 (1) Journal of Law and Courts 2014: 33-65.
7. Philipp Koker, “Poland – Judicial independence in jeopardy? President Duda refuses appointment of ten further judges” (25 July 2016), UCL Blog.
8. Richard L Vining Jr et al, “Bias and the Bar: Evaluating the ABA Ratings of Federal Judicial Nominees”, April 2009.

*В. Эрх зүйн эх сурвалж:*

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992).
2. Шүүхийн тухай хууль (1993)
3. Шүүхийн тухай хууль (2002)
4. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012)
5. Шүүхийн захиргааны тухай хууль (2012)
6. Монгол Улсын шүүхийн тухай хууль (2021).
7. Шүүхийн ерөнхий зөвлөлийн холбогдох тогтоолууд.
8. Харьцуулсан судалгаанд холбогдох улсуудын Үндсэн хууль.

*Г. Шүүхийн шийдвэр:*





1. Үндсэн хуулийн цэцийн гишүүний 1998 оны 47 дугаар тогтоол.
2. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр. 2025.04.14, 128/ШШ2025/0261.
3. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр. 2023.03.10, 128/ШШ2023/0201. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр. 2022.02.08, 128/ШШ2022/0070.
4. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал. 2025.06.30, Дугаар 0017.
5. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал. 2023.04.26, 221/МА2023/0278.





*Д. Цахим эх сурвалж:*




1. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, <https://shuukh.mn/>
2. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn>
3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас, <https://judcouncil.mn/>
4. Монгол Улсын хууль зүйн судалгааны эх сурвалжийн цахим сан, <https://legaldata.mn/>

## ХАВСРАЛТ

### Асуумжийн үр дүн







12. Танд шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой санал, зөвлөмж байгаа бол бичнэ үү.

мэргэшлийн хороо байгуулах, сонгон шалгаруулалтын шалгалтын төрлийг оновчтой, зохистой болгох, ШЕЗ-ийн үнэлгээний аргачлалыг тодорхой буюу аль болох объектив шалгуурыг харгалздаг болгох, шалгалтын зохион байгуулалт буюу нэг өдөрт өгөх шалгалтын тоо, мөн нэг шалгалтад зарцуулах хугацааг оновчтой тогтоох, шалгалтад хэрэглэх программ хангамж, түүний нууцлалыг сайжруулах

Давах, хяналтын шатны шүүхэд шүүгч нар шалгалт өгөх үед ШЕЗ өөрсдөдөө байгаа мэдээллээ шаарддагаа болих, Сэтгэцийн дүгнэлт хэрэггүй. Мэргэжлийн хороог бий болгох.

Давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчдээс давхардсан олон баримт бүрдүүлж байгаа нь маш хүндрэлтэй. Анхан шатны шүүхийн шүүгчээр 6-аас дээш ажилласан шүүгч давж заалдах шатны шүүхэд шалгалт өгч байхад, сэтгэцийн дүгнэлт шаарддагыг болиулах, бас тэр олон хуудас баримт бүрдүүлж байгааг болиулах шаардлагатай.

Мэргэшил ёс зүй зан төлөвийн шалгалтыг 10 гишүүн шүүгчид нэр дэвшигчтэй биечилж уулзаж авч бгаа нь өөрийн гаргах хүсэлтэй хүндээ оноог тултал өгөх, таньдаг хүнээ зөөлөн дүгнэх зэргээр сөрөг нөлөөлөл орно, бусад шалгалт шиг хэнийг дүгнэж бгаа нь мэдэгдэхгүй бичгийн хэлбэрээр бх нь зүйтэй.

Мэргэшлийн хороог байгуулж, шалгалтыг авдаг болох

Шалгалтын мэргэшсэн хороог байгуулах шаардлагатай

Шалгалтын босгыг буулгахгүй байх. Харин шалгалтын боловсруулалт, үнэлгээнд анхаарах

нэр дэвшигчдийн ёс зүйн байдлыг маш нарийн, өндөр шалгуураар шалгаж авах хэрэгтэй. ерөнхий хууль зүйн мэдлэг сайн боловч хувь хүний, мэргэжлийн ёс зүй хангалтгүй хүмүүсийг тэнцүүлдэг. ёс зүйгүй шүүгч авлига, ёс зүйн асуудалд орж, нийт шүүгчдийн нэр хүндийг хамгийн ихээр унагадаг.

Тэнцсэн шүүгчээс мэргэшил, зан төлөв ёс зүйн шалгалт авахдаа хэрэг шийдвэрлэсэн тоо, хугацаандаа эрхийн акт гаргаж байгаа зэрэгт үнэлгээ тавих.

Давах хяналтын шатанд нэр дэвшигчийн шийдвэрийн чанарыг харгалзаж үзнэ гэдэг бол нэг талаасаа үнэхээр болохгүй зүйл!!! Учир нь хэргээ давуулахгүй, хянуулахгүйн тулд эхийг нь эцээхгүй тугалыг нь тураахгүй яг дундуур нь шийддэг шүүгч нар маш их байна. Хэрэг нь бараг давдаггүй, гэтэл тэрийг маш сайн шийдвэр гаргасан гэж үнэлж огт болохгүй.

Гишүүд мэдлэг чадвараар томилогддоггүй учир шүүгчийн шалгалт авах чадамж чадваргүй. Туслах, өмгөөлөгч нараар дүгнүүлэх нь зохимжтой биш. Шалгалт бодитой дүгнэгдэж чадахгүй. Мэргэжлийн хороо байж Гишүүд нь нууцаар сонгогдох ёстой.

ШЕЗ гишүүд чадваргүй, субъектив ханддаг. Дээд шатны шүүгчийн шалгалт авах чадамжгүй. Шалгалт нууцлалтай мэргэжлийн мэргэжилтэн хэнд дүн тавьж бгаагаа мэдэх боломжгүй байхаар журамлах. Давах хяналтын шатны шүүхийн шүүгч нарын ажилласан жилийг нэмэгдүүлэх. Шалгалтын хугацаа 1 жилийн дотор унасан бол дахин өгөх эрхгүй бхаар хуульчлах. Тэгэхгүй бол жилд олон удаа шалгалт өгөөд мэргэшсэн хүмүүс тэнцээд байна. Жинхэнэ чадварлаг шүүгч нар бүрдүүлэх баримт их учир оролцож чадахгүй чадваргүй хүмүүс томилогдон дээд шатны шүүхийн чадвар муудаж байна

Хуульчдын дунд хүлээн зөвшөөрөгдсөн чадварлаг шүүгч нар дээд шатанд гарч чадахгүй чадваргүй шүүгч нар оновчгүй шалгалтын улмаас дээш гарч шүүхийн нэр хүнд унаж байгаа

Шүүгчийн цалин чадварлаг хуульчийн орлоготой харьцуулахад хэт бага учраас уг хуульчид сонгон шалгаруулалтад огт орохыг хүсдэггүй. шүүгч болж элдэв хүлээсэнд орж байснаас одоогийн ажлаа хийж байсан нь дээр гэж олон хүнээс сонсож байв.

Шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой журмыг боловсронгуй болгох шаардлагатай. Мэдлэг ур чадварын шалгалтын Мэргэшлийн хороо, ёс зүй зан төлөвийн шалгалтын ШЕЗ авдаг болох хэрэгтэй

1.Эрүүл мэндийн дүгнэлтийг орон нутагт мэргэжлийн эмч нар гаргадаг түүнийг материалд тооцдог болох одоогийн практикаар зөвхөн СЭМҮТөөс буюу нэг эмнэлгээс авч байгаа нь тухайн байгууллагад зохиомол ачаалал үүсгэхээс гадна шалгалтад нэр дэвшигчид хүндрэл үүсгэж буйг өөрчлөх 2. Нөөцөд байгаа нэр дэвшигчээс дахин материал бүрдүүлж авдаг, бүртгэлийн хугацаагаар хасдаг хавчдаг зэргийг болиулах журмаас хасах буюу хүсэлтээ өгөөд л болдог байсан өмнөх зохицуулалтаар зохицуулах 3. Цахим шүүх хүрээнд Давах хяналтын шатны шүүхэд нэр дэвшиж буй шүүгчийн материалыг ШЕЗ-н хүний нөөцийн программаас шууд татах боломжийг нээж өгөх 4. Шүүхийн мэргэшлийн хороо зэрэг мэргэшсэн байгууллагыг байгуулах эсхүл шүүгчээс шалгалт авахуйц хэмжээнд бэлтгэгдсэн байх шаардлагыг гишүүдэд тавих 5. Шат шатны шүүхэд шалгалт өгөх нэр дэвшигчийн бүрдүүлэх материалыг өөрчлөх тодруулбал туршлага ур чадварыг үнэлэх дүгнэлт материалд анхаарах зэрэгт санал өгч байна

Мэргэшлийн хороог байгуулах

Шүүгчийн сонгон шалгаруулалтын энэ тогтолцоогоо хадгалж үлдэх хэрэгтэй. онооны эрэмбээр Ерөнхийлөгчид санал болгож байгаа маш зөв.

Гэмт хэрэгт холбогдсон нэр дэвшигчийг бүртгэж, томилуулах санал гаргаж байгааг буруу гэж боддог. Мөн Ерөнхийлөгч томилохоос татгалзаж байгаа үндэслэлийг тодорхой болгох, ШЕЗ-ийн гишүүд шүүгчийг сонгон шалгаруулах мэдлэг, ур чадвартай эсэхэд эргэлздэг



